



# ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

2024 оны 07 дугаар сарын 29  
№28 (1324)

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН  
ТАМГЫН ГАЗАР



## ГАРЧИГ

### МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

459.	Мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих тухай	2387
460.	Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд нэмэлт оруулах тухай	2411
461.	Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуульд нэмэлт оруулах тухай	2413
462.	Харилцаа холбооны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай	2415
463.	Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	2417
464.	Хөрөнгийн үнэлгээний тухай хуульд нэмэлт оруулах тухай	2419
465.	Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай	2420
466.	Засгийн газрын бүтцийн тухай	2446
467.	Засгийн газрын бүрэлдэхүүний тухай	2448
468.	Монгол Улсын Засгийн газрын бүтцийн тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай	2452
469.	Монгол Улсын Засгийн газрын бүрэлдэхүүний тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай	2453

470.	Төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай		2454
471.	Засгийн газар дахь хяналтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай		2456
472.	Өрсөлдөөний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай		2458
473.	Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай		2460
474.	Зөвшөөрлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай		2461
475.	Бүсчилсэн хөгжлийн удирдлага зохицуулалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай		2462
<b>МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ</b>			
476.	Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө батлах тухай	Дугаар 46	2464
477.	Зарим Байнгын хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай	Дугаар 06	2518
478.	Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн даргын үүрэгт ажлаас чөлөөлөх тухай	Дугаар 07	2520
479.	Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн даргыг томилох тухай	Дугаар 08	2522
480.	Зарим Байнгын хорооны дарга нарыг сонгох тухай	Дугаар 09	2524

481.	Тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай	Дугаар 10	2526
482.	Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай	Дугаар 11	2528
483.	Хуулийн төсөл буцаах тухай	Дугаар 12	2530
484.	Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвчийг шинэчлэн батлах тухай	Дугаар 13	2532
485.	Зарим Байнгын хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай	Дугаар 14	2540
486.	Зарим Байнгын хорооны дарга нарыг сонгох тухай	Дугаар 15	2542
487.	Монгол Улсын Их Хурлын зарим дэд хорооны бүрэлдэхүүний тухай	Дугаар 16	2544



2220.	Урьдчилсан үнэмлэхүй үнэ /сая. /төг	50	45000
2230.	Урьдчилсан үнэмлэхүй үнэ /сая. /төг	50	45000
2240.	Урьдчилсан үнэмлэхүй үнэ /сая. /төг	50	45000
2250.	Урьдчилсан үнэмлэхүй үнэ /сая. /төг	50	45000
2260.	Урьдчилсан үнэмлэхүй үнэ /сая. /төг	50	45000
2270.	Урьдчилсан үнэмлэхүй үнэ /сая. /төг	50	45000
2280.	Урьдчилсан үнэмлэхүй үнэ /сая. /төг	50	45000
2290.	Урьдчилсан үнэмлэхүй үнэ /сая. /төг	50	45000
2300.	Урьдчилсан үнэмлэхүй үнэ /сая. /төг	50	45000





## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2024 оны 06 дугаар  
сарын 05-ны өдөр

Улаанбаатар  
хот

### МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИЙН ҮЙЛДВЭРЛЭЛИЙГ ДЭМЖИХ ТУХАЙ

#### НЭГДҮГЭЭР БҮЛЭГ НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

##### 1 дүгээр зүйл.Хуулийн зорилт

1.1.Энэ хуулийн зорилт нь мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих талаар төрөөс баримтлах бодлогыг тодорхойлох, мэдээллийн технологийн үйлдвэрлэл эрхэлж байгаа хүн, хуулийн этгээдийг дэмжих, санхүүжүүлэх эх үүсвэрийг төрөлжүүлэх, хөрөнгө оруулалтын эрх зүйн орчныг боловсронгуй болгох, мэдээллийн технологийн үйлдвэрлэлийн эдийн засагт үзүүлэх үр өгөөжийг нэмэгдүүлэх цахим эдийн засгийг дэмжихэд оршино.

##### 2 дугаар зүйл.Мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих хууль тогтоомж

2.1.Мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль<sup>1</sup>, энэ хууль болон эдгээр хуультай нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

2.2.Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

##### 3 дугаар зүйл.Хуулийн үйлчлэх хүрээ

3.1.Энэ хууль нь төрөөс мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих талаар баримтлах бодлого, зарчим, чиг үүргийг тодорхойлж, мэдээллийн технологийн үйлдвэрлэл эрхэлж байгаа хүн, хуулийн этгээдэд дэмжлэг үзүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулна.

##### 4 дүгээр зүйл.Хуулийн нэр томъёоны тодорхойлолт

4.1.Энэ хуульд хэрэглэсэн дараах нэр томъёог доор дурдсан утгаар ойлгоно:

4.1.1.“гарааны компани” гэж Инновацийн тухай хуулийн

3.1.8-д заасныг;

<sup>1</sup> Монгол Улсын Үндсэн хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 1992 оны 01 дугаарт нийтлэгдсэн.





4.1.2.“дэвшилтэт технологи” гэж шинжлэх ухааны судалгаа, мэдлэгт суурилсан мэдээллийн технологийн шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээг бий болгох, хөгжүүлэх технологийг;

4.1.3.“мэдээллийн технологи” гэж компьютер, харилцаа холбооны сүлжээ ашиглан тоон өгөгдлийг үүсгэх, боловсруулах, хадгалах, дамжуулах, солилцох, үйлчилгээ үзүүлэх, бусад тоног төхөөрөмжтэй холбогдох үйл ажиллагааг;

4.1.4.“мэдээллийн технологийн үйлдвэрлэл” гэж мэдээллийн технологийн бүтээгдэхүүн, үйлчилгээг шинээр бий болгох, хөгжүүлэх, түгээх, үйлчилгээ үзүүлэхийг;

4.1.5.“мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих виртуал бүс” гэж мэдээллийн технологийн үйлдвэрлэл эрхлэгч хуулийн этгээдийг цахим хэлбэрээр бүртгэсний үндсэн дээр энэ хуульд заасан дэмжлэг үзүүлэх зорилготой бүсийг;

4.1.6.“сэндбокс орчин” гэж мэдээллийн технологийн шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээг бий болгох, хөгжүүлэх, сайжруулах, бодит орчинд турших боломж олгох зорилго бүхий орчныг.

## **5 дугаар зүйл.Мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих талаар баримтлах зарчим**

5.1.Төрөөс мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих талаар баримтлах бодлогыг тодорхойлох, мэдээллийн технологийн үйлдвэрлэл эрхэлж байгаа хүн, хуулийн этгээдэд дэмжлэг үзүүлэхэд дараах зарчмыг баримтлан ажиллана:

5.1.1.төр, хувийн хэвшлийн түншлэлд тулгуурлах;

5.1.2.төр мэдээллийн технологийн шинэ бүтээгдэхүүн үйлдвэрлэхээс татгалзаж, худалдан авах ажиллагаагаар хэрэгжүүлэх;

5.1.3.мэдээллийн технологийн үйлдвэрлэл эрхэлж байгаа хүн, хуулийн этгээдэд үзүүлэх дэмжлэг нь олон нийтэд ил тод, нээлттэй, шударга байх;

5.1.4.мэдээллийн технологийн үйлдвэрлэлд хүн, хуулийн этгээд тэгш эрхтэй, чөлөөтэй оролцох;

5.1.5.мэдээллийн технологийн үндэсний үйлдвэрлэлийг хөгжүүлэх.



## **ХОЁРДУГААР БҮЛЭГ МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИЙН ҮЙЛДВЭРЛЭЛИЙГ ДЭМЖИХ ТАЛААР ТӨРИЙН БАЙГУУЛЛАГЫН ХҮЛЭЭХ НИЙТЛЭГ ҮҮРЭГ**

### **6 дугаар зүйл.Мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих талаар Засгийн газрын бүрэн эрх**

6.1.Засгийн газар мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

6.1.1.төрөөс мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг хөгжүүлэх, дэмжлэг үзүүлэхтэй холбогдсон дүрэм, журмыг хууль тогтоомжид нийцүүлэн батлах;

6.1.2.мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих виртуал бүс байгуулах;

6.1.3.мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжихэд шаардлагатай улсын төсвийн хөрөнгө оруулалт, санхүүжилтийн хэмжээг тодорхойлох;

6.1.4.энэ хуулийн 4.1.2-т заасан дэвшилтэт технологийн жагсаалтыг цахим хөгжил, харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн батлах;

6.1.5.бүх нийтийн цахим ур чадварын бүтцийн хүрээг батлах;

6.1.6.хиймэл оюун ухаан, их өгөгдөл, блокчэйн, сансрын үйлдвэрлэлийн дэвшилтэт технологид суурилсан сэндроксыг байгуулж, холбогдох журам батлах.

### **7 дугаар зүйл.Төрийн болон нутгийн өөрөө удирдах байгууллагын чиг үүрэг**

7.1.Төрийн болон нутгийн өөрөө удирдах байгууллага мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих талаар дараах нийтлэг үүрэг хүлээнэ:

7.1.1.төрийн бодлого, төлөвлөгөө, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангахад цахим хөгжил, харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай хамтран ажиллах;

7.1.2.мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих талаар хүн, хуулийн этгээдтэй хамтран ажиллах, мэдээллийн технологийн бүтээгдэхүүн, үйлчилгээг худалдан авах ажиллагаагаар хэрэгжүүлэх, төсөл, арга хэмжээг санхүүжүүлэх;



7.1.3.мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжихэд шаардагдах хөрөнгийг төсөвтөө багтаан шийдвэрлэх;

7.1.4.хөгжлийн тэргүүлэх болон дэвшилтэт технологийн жагсаалтад багтсан чиглэлээр судалгаа шинжилгээний ажил, төсөл, хөтөлбөрийг их, дээд сургууль, эрдэм шинжилгээний байгууллагаар гүйцэтгүүлэх;

7.1.5.хуульд заасан бусад.

7.2.Мэдээллийн технологийн бүтээгдэхүүн, үйлчилгээг олон улсад сурталчлан таниулахад шаардагдах зардлыг санхүүжүүлж болно.

7.3.Төрийн захиргааны төв байгууллага бүх нийтийн цахим ур чадварын бүтцийн хүрээнд нийцүүлэн салбарын онцлог бүхий сургалтын хөтөлбөр, агуулгыг боловсруулахад цахим хөгжил, харилцаа холбооны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний саналыг авна.

7.4.Төсвийн байгууллага программ хангамжийг хүн, хуулийн этгээдээс худалдан авахдаа программ хангамжийн эх кодыг захиалагч, эсхүл түүний нэр заасан этгээд, эсхүл гүйцэтгэгч эзэмших нөхцөлийг тендер шалгаруулалтын баримт бичигт тусгаж, харилцан тохиролцоно.

7.5.Төсвийн байгууллага өөрийн эзэмшиж байгаа программ хангамжийн эх кодыг гадаад улсад гэрээний үндсэн дээр ашиглуулж болно.

## **8 дугаар зүйл.Цахим хөгжил, харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын чиг үүрэг**

8.1.Цахим хөгжил, харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих талаар дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

8.1.1.мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах;

8.1.2.мэдээллийн технологийн салбарын хууль тогтоомж, бодлогын баримт бичиг, дүрэм, журам, стандартыг боловсруулахад мэргэжлийн холбоотой хамтран ажиллах;

8.1.3.мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих талаар оролцогч талуудын түншлэл, салбар хоорондын үйл ажиллагааны уялдаа холбоог хангах;



8.1.4.бүх нийтийн цахим ур чадварын түвшнийг үнэлэх, соён гэгээрүүлэх ажлыг тогтмол зохион байгуулах;

8.1.5.мэдээллийн технологийн салбарын хүний нөөцийн эрэлт хэрэгцээний судалгааг тогтмол хийх, хөдөлмөрийн зах зээл дээрх эрэлт, нийлүүлэлтийг хангахад чиглэсэн бодлого, арга хэмжээг боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай хамтран хэрэгжүүлэх;

8.1.6.мэдээллийн технологийн бүтээгдэхүүний оюуны өмч, зохиогчийн эрхийг хамгаалах, эдийн засгийн эргэлтэд оруулахад дэмжлэг үзүүлэх, бодлогын судалгаа шинжилгээ хийх, дэвшилтэт технологийн судалгаа хөгжүүлэлтийг дэмжих;

8.1.7.үндэсний мэдээллийн технологийн бүтээгдэхүүн, үйлчилгээг олон улсад таниулахад дэмжлэг үзүүлэх;

8.1.8.мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг хөгжүүлэх талаар гадаад улс, олон улсын байгууллагатай хамтран ажиллах.

## **9 дүгээр зүйл.Мэдээллийн технологийн үндэсний паркийн чиг үүрэг**

9.1.Мэдээллийн технологийн үндэсний парк дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

9.1.1.дэвшилтэт технологийг хөгжүүлэх, экспортын чиг баримжаатай үндэсний үйлдвэрлэлийг хөгжүүлэх, хэрэглээнд нэвтрүүлэхэд чиглэсэн судалгаа хийх, хэрэгцээ, шаардлагыг тодорхойлох, техник, эдийн засгийн үндэслэлийг боловсруулах;

9.1.2.мэдээллийн технологийн бүтээгдэхүүн, үйлчилгээг зах зээлд гаргахад мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлэх, гарааны компанийн үйл ажиллагааг уялдуулах;

9.1.3.мэдээллийн технологийн тэмцээн, уралдаан зохион байгуулах, хүний нөөц бэлтгэх чиглэлээр дотоод, гадаадын их, дээд сургууль, эрдэм шинжилгээний байгууллага болон хүн, хуулийн этгээдтэй хамтран ажиллах;

9.1.4.мэдээллийн технологийн бүтээгдэхүүн, үйлчилгээг хөгжүүлэхэд биет болон биет бус хэлбэрээр хөрөнгө оруулалтыг татах;



9.1.5.үндэсний мэдээллийн технологийн бүтээгдэхүүн, үйлчилгээг олон улсад сурталчлах, гадаад аутсорсингийн үйлчилгээг дэмжихэд чиглэсэн арга хэмжээг зохион байгуулах;

9.1.6.мэдээллийн технологийн бүтээгдэхүүн, үйлчилгээг хүн, хуулийн этгээдээс худалдан авах нэг цонхны бүртгэлийн системийг хариуцан ажиллуулах;

9.1.7.мэдээллийн технологийн үйлдвэрлэл эрхлэгч хуулийн этгээдэд зориулан инкубатор, хамтын оффис ажиллуулах, инкубаторт элсэх хуулийн этгээдэд тавигдах шаардлагыг тодорхойлох;

9.1.8.мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих виртуал бүсийн Зөвлөлийн ажлын албаны чиг үүргийг гүйцэтгэх;

9.1.9.мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих виртуал бүсэд хуулийн этгээдийг бүртгэх, хуульд заасан үндэслэлээр бүртгэлээс хасах;

9.1.10.мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих виртуал бүсэд бүртгэлтэй хуулийн этгээдийн зах зээлийн үнэлгээг Хөрөнгийн үнэлгээний тухай<sup>2</sup> хуулийн 22 дугаар зүйлд заасан хөрөнгийн үнэлгээний мэргэжлийн байгууллагатай хамтран хэрэгжүүлэх;

9.1.11.дотоод болон гадаадын зах зээлд нийлүүлэх мэдээллийн технологийн бүтээгдэхүүн, үйлчилгээг ангилал, төрөл, зориулалт, зохиогчийн эрх болон бусад нэмэлт мэдээллийн хамт бүртгэх.

## **10 дугаар зүйл.Төр, хувийн хэвшлийн түншлэл**

10.1.Төр, хувийн хэвшлийн түншлэлээр төсөл санаачлах, хэрэгжүүлэхтэй холбоотой энэ хуульд зааснаас бусад харилцааг Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай<sup>3</sup> хуульд заасны дагуу зохицуулна.

10.2.Төрийн байгууллага мэдээллийн технологийн үйлдвэрлэлтэй холбоотой дараах чиг үүргийг гэрээний үндсэн дээр бусад этгээдээр гүйцэтгүүлж, холбогдох зардлыг бүрэн, эсхүл хэсэгчлэн санхүүжүүлж болно:

10.2.1.төрийн үйлчилгээг хүн, хуулийн этгээдэд хүргэхэд ашиглах дэвшилтэт технологийг хөгжүүлэх, нэвтрүүлэх, түүний засвар, арчлалт, үйлчилгээ, аюулгүй байдлыг хангах;

<sup>2</sup> Хөрөнгийн үнэлгээний тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2022 оны 37 дугаарт нийтлэгдсэн.

<sup>3</sup> Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2023 оны 12 дугаарт нийтлэгдсэн.



10.2.2.энэ хуулийн 8.1.4-т заасан бүх нийтийн цахим ур чадварын түвшнийг үнэлэх, соён гэгээрүүлэх ажлыг тогтмол зохион байгуулах;

10.2.3.энэ хуулийн 8.1.5-д заасан мэдээллийн технологийн салбарын хүний нөөцийн эрэлт хэрэгцээний судалгааг тогтмол хийх.

## **ГУРАВДУГААР БҮЛЭГ МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИЙН ҮЙЛДВЭРЛЭЛИЙГ ДЭМЖИХ ВИРТУАЛ БҮС**

### **11 дүгээр зүйл.Мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих виртуал бүс**

11.1.Монгол Улс мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих виртуал бүс /цаашид “виртуал бүс” гэх/-тэй байна.

11.2.Мэдээллийн технологийн үйлдвэрлэл, дэвшилтэт технологийг хөгжүүлэх, виртуал бүсийн үйл ажиллагааг удирдлага, зохион байгуулалтаар хангах үүрэг бүхий Үндэсний зөвлөл /цаашид “Зөвлөл” гэх/ ажиллах бөгөөд уг Зөвлөлийн бүрэн эрхийн хугацаа 3 жил байна.

11.3.Зөвлөлийг Монгол Улсын Ерөнхий сайд тэргүүлж, дэд даргаар Цахим хөгжил, харилцаа холбооны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн ажиллана.

11.4.Зөвлөлийн бүрэлдэхүүн нь эдийн засгийн, санхүү, төсвийн, цахим хөгжил, харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын болон мэргэжлийн холбоо, хувийн хэвшлийн байгууллагын төлөөллөөс бүрдэнэ. Зөвлөлийн бүрэлдэхүүний 50-аас доошгүй хувь нь мэргэжлийн холбоо, хувийн хэвшлийн байгууллагын төлөөлөл байна.

11.5.Зөвлөлийн үйл ажиллагааны үндсэн хэлбэр нь хуралдаан байх бөгөөд Зөвлөлийн шийдвэр нь тогтоол, зөвлөмж, мэдэгдэл хэлбэртэй байна.

11.6.Зөвлөл дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

11.6.1.мэдээллийн технологийн үйлдвэрлэл, дэвшилтэт технологийг хөгжүүлэх стратеги төлөвлөгөө, төсвийн төслийг хэлэлцэн батлах;

11.6.2.виртуал бүсийн үйл ажиллагааны тайланг хэлэлцэж, зөвлөмж гаргах;

11.6.3.энэ хуулийн 9.1.8-д заасан Зөвлөлийн ажлын албаны үйл ажиллагаанд хяналт тавих, чиглэл өгөх.

11.7.Зөвлөлийн бүрэлдэхүүн, түүний ажиллах журам болон виртуал бүсийн ажиллах журмыг Засгийн газар батална.

11.8.Зөвлөлийн бүрэлдэхүүн, үйл ажиллагаа олон нийтэд ил тод, нээлттэй байна.

## **12 дугаар зүйл.Мэдээллийн технологийн үйлдвэрлэл эрхлэгч хуулийн этгээдийг виртуал бүсэд бүртгэх, бүртгэлээс хасах**

12.1.Зөвлөлийн ажлын алба мэдээллийн технологийн үйлдвэрлэл эрхлэгч хуулийн этгээд /цаашид “хуулийн этгээд” гэх/-ээс Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай<sup>4</sup> хуулийн 18.5.6-д заасан төрийн үйлчилгээний нэгдсэн системээр дамжуулан цахим хэлбэрээр ирүүлсэн хүсэлтийг хүлээн авч, ажлын 3 өдрийн дотор хянаж, дараах шаардлагыг хангасан тохиолдолд виртуал бүсэд бүртгэж, хариу мэдэгдэнэ.

12.1.1.хуулийн этгээдийн бүртгэлийн мэдээлэл;

12.1.2.хуулийн этгээдийн ажилтны нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн талаарх тодорхойлолт;

12.1.3.хуулийн этгээдийн эхлэлтийн баланс, эсхүл өмнөх жилийн санхүүгийн тайлан.

12.2.Зөвлөлийн ажлын алба нь виртуал бүсэд бүртгүүлсэн хуулийн этгээдтэй цахим хэлбэрээр гэрээ байгуулах бөгөөд уг гэрээний загварыг Зөвлөл батална.

12.3.Виртуал бүсэд бүртгүүлсэн хуулийн этгээдийн нэр, эцсийн өмчлөгчийн мэдээллийг нээлттэй, ил тод байршуулна.

12.4.Зөвлөлийн ажлын алба нь бүртгэлтэй хуулийн этгээдийг дараах үндэслэлээр бүртгэлээс хасна:

12.4.1.хуулийн этгээд нь виртуал бүсэд бүртгүүлсэн өдрөөс хойш 1 жилийн хугацаанд гэрээ, дүрэмд заасан мэдээллийн технологийн үйлдвэрлэл эрхлээгүй;

<sup>4</sup> Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2022 оны 06 дугаарт нийтлэгдсэн.

12.4.2.мэдээллийн технологийн үйлдвэрлэлээс бусад төрлийн үйл ажиллагааг виртуал бүсээр дамжуулан эрхэлсэн;

12.4.3.гэрээ, дүрэмд заасан мэдээллийн технологийн үйлдвэрлэл эрхэлсэн боловч дараалсан 12 сараас дээш хугацаанд үйл ажиллагаа нь өөрөөс хамаарах шалтгаанаар тасалдсан, зогссон;

12.4.4.Иргэний хуулийн 32.1-д заасны дагуу татан буулгасан.

## **ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ ВИРТУАЛ БҮСЭД БҮРТГҮҮЛСЭН ХУУЛИЙН ЭТГЭЭДЭД ҮЗҮҮЛЭХ ДЭМЖЛЭГ**

### **13 дугаар зүйл.Татварын болон татварын бус дэмжлэг**

13.1.Виртуал бүсэд бүртгүүлсэн хуулийн этгээд нь санхүүгийн болон татварын тайланг холбогдох журмын дагуу гаргаж, Зөвлөлийн ажлын албанд жил бүрийн нэгдүгээр улиралд багтаан хүргүүлнэ.

13.2.Виртуал бүсэд бүртгэлтэй хуулийн этгээдэд үзүүлэх татварын дэмжлэгийг холбогдох хуульд заасны дагуу үзүүлнэ.

13.3.Виртуал бүсэд бүртгэлтэй хуулийн этгээдэд улсын төсвөөс санхүүжүүлэх дараах татварын бус дэмжлэг үзүүлнэ:

13.3.1.мэдээллийн технологийн бүтээгдэхүүнийг дотоодын болон гадаадын холбогдох байгууллагад патентжуулах зардлыг санхүүжүүлэхэд грант олгох;

13.3.2.экспортод чиглэсэн мэдээллийн технологийн бүтээгдэхүүний олон улсын чанар, стандартын баталгаажуулалтын зардлыг санхүүжүүлэхэд бүхэлд нь, эсхүл хэсэгчлэн грант олгох;

13.3.3.виртуал бүсэд бүртгэгдсэн мэдээллийн технологийн үйлдвэрлэл эрхлэгчийн төлсөн нийгмийн даатгалын шимтгэл төлөлтөд нөхөн олговор олгох;

13.3.4.хиймэл оюун ухаанд суурилсан төсөл, арга хэмжээний нийт өртгийн 60 болон түүнээс дээш хувийг өөрийн хөрөнгөөр санхүүжүүлсэн тохиолдолд үлдэх хэсэгт грант олгох;

13.3.5.дэвшилтэт технологид суурилсан бүтээгдэхүүн, үйлчилгээг бий болгосон патент эзэмшигчид шагнал, урамшуулал олгох;





13.3.6.Зээлийн батлан даалтын сангийн тухай<sup>5</sup> хуульд заасан нөхцөл журмын дагуу зээлийн батлан даалт гаргах;

13.3.7.экспортод гаргасан болон оюуны өмчид бүртгүүлсэн бүтээгдэхүүн, үйлчилгээ бүрд судалгаа, хөгжүүлэлтийн зардлын 70 хүртэлх хувьтай тэнцэх нэг удаагийн дэмжлэгийг дотоодын мэдээлэл технологийн гарааны компанид олгох;

13.3.8.мэдээллийн технологийн бүтээгдэхүүн, үйлчилгээний төсөл хэрэгжүүлэхээр авсан зээлийн хүүгийн тодорхой хувийг санхүүжүүлэх;

13.3.9.мэдээллийн технологийн үйлдвэрлэл эрхэлж гарааны компанид эд хөрөнгийн түргэвчилсэн элэгдэл хорогдол тооцох.

13.4.Энэ хуулийн 13.2, 13.3-т заасан татварын болон татварын бус дэмжлэг үзүүлэх журмыг Засгийн газар батална.

#### **14 дүгээр зүйл.Мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих дэмжлэгийн эх үүсвэр**

14.1.Виртуал бүсэд бүртгүүлсэн хуулийн этгээдэд үзүүлэх дэмжлэг нь дараах эх үүсвэрээс бүрдэнэ:

14.1.1.мэдээллийн технологийн үйлдвэрлэлээс төсөвт төвлөрүүлсэн мөнгөн хөрөнгийн 40-өөс доошгүй хувьтай тэнцэх хэмжээний хөрөнгө;

14.1.2.гадаад улс, олон улсын байгууллага, түүнчлэн, дотоод, гадаадын аж ахуйн нэгж, байгууллага, иргэнээс өгсөн хандив, тусламж;

14.1.3.энэ хуулийн 7.4-т заасны дагуу төсвийн байгууллагын өөрийн эзэмшиж байгаа программ хангамжийн эх кодыг гадаад улсад ашиглуулснаас олсон орлого;

14.1.4.Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн<sup>6</sup> 5.3.5, 5.3.18, 5.3.20-д заасан Засгийн газрын тусгай сангийн хөрөнгийн 5-аас доошгүй хувь.

<sup>5</sup> Зээлийн батлан даалтын сангийн тухай хууль "Төрийн мэдээлэл" эмхэтгэлийн 2012 оны 09 дугаарт нийтлэгдсэн.

<sup>6</sup> Засгийн газрын тусгай сангийн тухай хууль "Төрийн мэдээлэл" эмхэтгэлийн 2019 оны 48 дугаарт нийтлэгдсэн.



**ТАВДУГААР БҮЛЭГ  
БУСАД ЗҮЙЛ**

**15 дугаар зүйл.Хууль зөрчигчид хүлээлгэх хариуцлага**

15.1.Энэ хуулийг зөрчсөн албан тушаалтны үйлдэл нь гэмт хэргийн шинжгүй бол Төрийн албаны тухай хуульд<sup>7</sup> заасан хариуцлага хүлээлгэнэ.

15.2.Энэ хуулийг зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Эрүүгийн хууль<sup>8</sup>, эсхүл Зөрчлийн тухай хуульд<sup>9</sup> заасан хариуцлага хүлээлгэнэ.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**Г.ЗАНДАНШАТАР**

<sup>7</sup> Төрийн албаны тухай хууль "Төрийн мэдээлэл" эмхэтгэлийн 2018 оны 01 дугаарт нийтлэгдсэн.

<sup>8</sup> Эрүүгийн хууль "Төрийн мэдээлэл" эмхэтгэлийн 2016 оны 07 дугаарт нийтлэгдсэн.

<sup>9</sup> Зөрчлийн тухай хууль "Төрийн мэдээлэл" эмхэтгэлийн 2017 оны 24 дугаарт нийтлэгдсэн.































## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2024 оны 06 дугаар  
сарын 05-ны өдөр

Улаанбаатар  
хот

### НИЙТИЙН МЭДЭЭЛЛИЙН ИЛ ТОД БАЙДЛЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд доор дурдсан агуулгатай 29.4, 29.5 дахь хэсэг нэмсүгэй:

“29.4. Мэдээлэл хариуцагч нийтийн мэдээллийн систем үүсгэхийн өмнө энэ хуулийн 29.5-д заасан ангилалд хамаарах системд техник, эдийн засгийн үндэслэлийг хийлгэж ирүүлнэ.

29.5. Техник, эдийн засгийн үндэслэл хийлгэх шаардлагатай нийтийн мэдээллийн системийн ангиллыг цахим хөгжил, харилцаа холбооны болон санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран тогтооно.”

**2 дугаар зүйл.** Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1 дэх хэсгийн “нийтийн мэдээллийн систем үүсгэхийн өмнө” гэсний өмнө “энэ хуулийн 29.4-т зааснаас бусад” гэж нэмсүгэй.

**3 дугаар зүйл.** Энэ хуулийг Мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА

Г.ЗАНДАНШАТАР





**Илэрхийлэл**

МОНГОЛЫН ХӨДӨӨ  
ЭРХЛЭГ

Утас: 7711 2222 / 7711 2223  
Факс: 7711 2224

МОНГОЛЫН ХӨДӨӨ  
ЭРХЛЭГ  
УТАС: 7711 2222 / 7711 2223  
ФАКС: 7711 2224

МОНГОЛЫН ХӨДӨӨ ЭРХЛЭГ  
УТАС: 7711 2222 / 7711 2223  
ФАКС: 7711 2224

МОНГОЛЫН ХӨДӨӨ ЭРХЛЭГ  
УТАС: 7711 2222 / 7711 2223  
ФАКС: 7711 2224

МОНГОЛЫН ХӨДӨӨ ЭРХЛЭГ  
УТАС: 7711 2222 / 7711 2223  
ФАКС: 7711 2224

МОНГОЛЫН ХӨДӨӨ ЭРХЛЭГ  
УТАС: 7711 2222 / 7711 2223  
ФАКС: 7711 2224

МОНГОЛЫН ХӨДӨӨ ЭРХЛЭГ  
УТАС: 7711 2222 / 7711 2223  
ФАКС: 7711 2224

МОНГОЛЫН ХӨДӨӨ  
ЭРХЛЭГ

УТАС: 7711 2222 / 7711 2223  
ФАКС: 7711 2224



## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2024 оны 06 дугаар  
сарын 05-ны өдөр

Улаанбаатар  
хот

### МӨНГӨ УГААХ БОЛОН ТЕРРОРИЗМЫГ САНХҮҮЖҮҮЛЭХТЭЙ ТЭМЦЭХ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуульд доор дурдсан агуулгатай 5.15 дахь хэсэг нэмсүгэй:

“5.15.Энэ хуулийн 5.2 дахь хэсэгт заасны дагуу харилцагчийг таньж мэдэх, холбогдох арга хэмжээг авахдаа нийтийн мэдээллийн дэд бүтцийг ашиглан таньж, баталгаажуулж болох бөгөөд шаардлагатай тохиолдолд хүн, хуулийн этгээдээс цахим баримт бичгийг гаргуулан авч болно.”

**2 дугаар зүйл.** Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсгийн “мэдээллийн эх үүсвэр” гэсний дараа “, нийтийн мэдээллийн дэд бүтцийг” гэж нэмсүгэй.

**3 дугаар зүйл.** Энэ хуулийг Мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА

Г.ЗАНДАНШАТАР





## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2024 оны 06 дугаар  
сарын 05-ны өдөр

Улаанбаатар  
хот

### ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Харилцаа холбооны тухай хуулийн 1 дүгээр зүйлийн 1.1 дэх хэсэг, 3 дугаар зүйлийн 3.1.15 дахь заалт, 6 дугаар зүйлийн 6.1.15.б, 6.1.15.в, 6.1.15.г, 6.1.15.д дэд заалт, 6.1.17 дахь заалт, 13 дугаар зүйлийн 13.1.3 дахь заалт, 25 дугаар зүйлийн 25.2.8 дахь заалтын “харилцаа холбоо, мэдээллийн технологийн” гэснийг, мөн хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 дахь заалт, 6 дугаар зүйлийн 6.1.15.а дэд заалт, 6.1.16 дахь заалтын “харилцаа холбоо, мэдээллийн технологид тулгуурласан” гэснийг, мөн хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.3 дахь заалтын “харилцаа холбоо, мэдээллийн технологийн чиглэлээр” гэснийг, мөн зүйлийн 6.1.14 дэх заалтын “харилцаа холбоо, мэдээллийн технологитой холбогдсон” гэснийг “харилцаа холбооны” гэж тус тус өөрчилсүгэй.

**2 дугаар зүйл.** Харилцаа холбооны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.14 дэх заалт, 5 дугаар зүйлийн 5.1.5 дахь заалт, 6<sup>1</sup> дүгээр зүйл, 30<sup>1</sup> дүгээр зүйлийг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

**3 дугаар зүйл.** Энэ хуулийг Мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА

Г.ЗАНДАНШАТАР





## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2024 оны 06 дугаар  
сарын 05-ны өдөр

Улаанбаатар  
хот

### АЖ АХУЙН НЭГЖИЙН ОРЛОГЫН АЛБАН ТАТВАРЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд доор дурдсан агуулгатай 15.1.19 дахь заалт нэмсүгэй:

“15.1.19. Мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих тухай хуулийн 10.1-д заасан виртуал бүсэд бүртгүүлсэн этгээдэд өгсөн тусламж.”

**2 дугаар зүйл.** Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.5.4 дэх заалтын “Инновацийн тухай хуульд заасан гарааны компанийн дотоодод шинээр үйлдвэрлэсэн инновацийн бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээний борлуулалтын орлогод ногдох албан татварыг;” гэснийг “Инновацийн тухай хуульд заасан гарааны компанийн дотоодод шинээр үйлдвэрлэсэн инновацийн бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээ, Мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих тухай хуулийн 11.1-д заасан виртуал бүсэд бүртгүүлсэн хуулийн этгээдийн мэдээллийн технологийн бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээний борлуулалтын орлогод ногдох албан татварыг;” гэж өөрчилсүгэй.

**3 дугаар зүйл.** Энэ хуулийг Мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА

Г.ЗАНДАНШАТАР









## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2024 оны 07 дугаар  
сарын 10-ны өдөр

Улаанбаатар  
хот

### МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн дараах хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

#### 1/18 дугаар зүйлийн 3 дахь хэсэг:

“3.Засгийн газрын бүтцэд доор дурдсан яам ажиллана:

-Ерөнхий чиг үүргийн:

- 1/Эдийн засаг, хөгжлийн яам;
- 2/Гадаад харилцааны яам;
- 3/Сангийн яам;
- 4/Хууль зүй, дотоод хэргийн яам;

-Чиглэлийн:

- 5/Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам;
- 6/Батлан хамгаалах яам;
- 7/Байгальорчин, уурамьсгалын өөрчлөлтийн яам;
- 8/Боловсролын яам;
- 9/Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам;
- 10/Зам, тээврийн яам;
- 11/Соёл, спорт, аялалжуулчлал, залуучуудын яам;
- 12/Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яам;
- 13/Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам;
- 14/Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яам;
- 15/Эрчим хүчний яам;
- 16/Эрүүл мэндийн яам.”

#### 2/20 дугаар зүйлийн 4 дэх хэсэг:

“4.Монгол Улсын Ерөнхий сайдын эрхлэх асуудлын хүрээнд дараах асуудал хамаарна:

-төрийн өмчийн бодлого;  
-тагнуул, сөрөг тагнуул, терроризмоос урьдчилан сэргийлэх асуудал;



- төрийн тусгай хамгаалалтын асуудал;
- жендэрийн хөгжлийн асуудал;
- зөвшөөрлийн нэгдсэн бодлого;
- газрын харилцаа, геодези, зураг зүйн асуудал.”

### **3/20 дугаар зүйлийн 5 дахь хэсэг:**

“5.Засгийн газрын гишүүн доор дурдсан хүрээний бодлогын төлөвлөлт, боловсруулалт, удирдлага, зохицуулалт болон дүн шинжилгээ хийх, үнэлгээ өгөх ажлыг эрхэлнэ:

1/Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд:

- хөгжлийн нэгдсэн бодлого, төлөвлөлт;
- макро эдийн засгийн бодлогын судалгаа, төлөвлөлт;
- шинжлэх ухаан, технологийн нэгдсэн бодлого, төлөвлөлт;
- эдийн засгийн болон хөгжлийн тэргүүлэх чиглэл, салбарыг тодорхойлж, салбар, дэд бүтцийн зохистой харьцааг тогтоох, төслүүдийн нэгдсэн бодлого;

-эдийн засгийн гадаад хамтын ажиллагаа, худалдааны нэгдсэн бодлого;

- хөрөнгө оруулалтын нэгдсэн бодлого, төлөвлөлт;
- аж үйлдвэрийн нэгдсэн бодлого, төлөвлөлт;
- төр, хувийн хэвшлийн түншлэлийн асуудал;
- хүн амын өсөлтийг дэмжих, хүний хөгжлийг хангах нэгдсэн бодлого;

- хүн амын нутагшилт, суурьшлын ерөнхий төлөвлөлт;
- оюуны өмч, патент, зохиогчийн эрхийн асуудал;
- агаарын бохирдлын эсрэг үйл ажиллагаа хэрэгжүүлэх асуудал.

2/Монгол Улсын Шадар сайд:

- бүсчилсэн хөгжлийн бодлого;
- чөлөөт бүс, эдийн засгийн тусгай бүсийн хөгжлийн нэгдсэн бодлого, төлөвлөлт;

- стандартчилал, хэмжил зүйн асуудал;
- тохирлын үнэлгээний итгэмжлэлийн асуудал;
- лабораторийн үйл ажиллагааны нэгдсэн бодлого, төлөвлөлт;

-гамшгаас хамгаалах асуудал;  
-хойшлуулшгүй сэргээн босгох ажиллагаатай холбоотой шуурхай асуудал;

-төрийн үйл ажиллагааны ил тод байдлыг хангах асуудал;  
-агаарын бохирдлын эсрэг үйл ажиллагаа хэрэгжүүлэх асуудал.

3/Монгол Улсын Шадар сайд:

-төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагаа;  
-гадаад худалдаа, хөрөнгө оруулалтын бодлого, зохицуулалт, бүртгэл;  
-шударга өрсөлдөөнийг дэмжих, хянан зохицуулах асуудал;

-хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах асуудал;  
-төрийн үйл ажиллагааны ил тод байдлыг хангах асуудал;  
-агаарын бохирдлын эсрэг үйл ажиллагаа хэрэгжүүлэх асуудал.

4/Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга:

-төрийн бүтээмж, нээлттэй засаглалын түншлэл, төрийн албаны хүний нөөцийн асуудал;

-Засгийн газрын дотоод мэдээлэл;  
-Засгийн газраас Ерөнхийлөгч, Улсын Их Хуралтай харилцах асуудал;

-орон нутгийн хөгжлийн нэгдсэн бодлого;  
-орон нутгийн удирдлага, зохион байгуулалт;  
-Засаг даргын үйл ажиллагааг удирдлага, зохицуулалтаар хангах асуудал;

-иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд үзүүлэх мэргэжил, арга зүйн туслалцаа;

-төрийн захиргааны төв байгууллагын шуурхай удирдлага, салбар хоорондын бодлого, зохицуулалтын уялдааг хангах асуудал;

-төрийн үйл ажиллагааны ил тод байдлыг хангах асуудал;  
-агаарын бохирдлын эсрэг үйл ажиллагаа хэрэгжүүлэх асуудал.

5/Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Монгол Улсын сайд, Хяналт, үнэлгээний Үндэсний хорооны дарга:

-хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрийн биелэлтэд хяналт тавих асуудал;

-хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавих асуудал;

-төрийн үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдлыг хангах асуудал;

-агаарын бохирдлын эсрэг үйл ажиллагаа хэрэгжүүлэх асуудал.

6/Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Монгол Улсын сайд, 20 минутын хот Үндэсний хорооны дарга:

-хотын хэт төвлөрлийг сааруулах асуудал;

-нийгмийн үйлчилгээг 20 минутын дотор авах хүнд ээлтэй шинэ орчин, нөхцөлийг бүрдүүлэх бодлогын зохицуулалт;

-авто замын түгжрэлийг бууруулах асуудал;

-төрийн үйл ажиллагааны ил тод байдлыг хангах асуудал;

-агаарын бохирдлын эсрэг үйл ажиллагаа хэрэгжүүлэх

асуудал.

7/Монгол Улсын сайд, Боомтын сэргэлтийн Үндэсний хорооны дарга:

-хилийн бүс дэх тээвэр, логистикийн нэгдсэн сүлжээг хөгжүүлэх;

-хилийн боомтын хөгжлийн бодлого, төлөвлөлт;

-хилийн боомтын болон стратегийн орд газрыг холбосон дэд бүтцийн бүтээн байгуулалт, шинэчлэл;

-төрийн үйл ажиллагааны ил тод байдлыг хангах асуудал;

-агаарын бохирдлын эсрэг үйл ажиллагаа хэрэгжүүлэх

асуудал.

8/Гадаад харилцааны сайд:

-гадаад улс, олон улсын байгууллагатай улс төрийн талаарх хамтын ажиллагаа;



-гадаад эдийн засгийн харилцаа, хамтын ажиллагаа;  
-гадаад худалдааны хэрэгжилт;  
-гадаадад байгаа Монгол Улсын иргэн, бизнесийн эрх ашгийг хамгаалах асуудал;

-гадаад улс, олон улсын байгууллагатай хийх гэрээ, хэлэлцээрийн асуудал болон байгуулсан гэрээ, хэлэлцээрийн явцад тавих хяналт;

-гадаад улс, олон улсын байгууллагатай хүмүүнлэгийн чиглэлээрх хамтын ажиллагаа;

-дипломат, албан зэргийн виз, консулын асуудал;  
-гадаад сурталчилгаа;  
-төрийн үйл ажиллагааны ил тод байдлыг хангах асуудал;  
-агаарын бохирдлын эсрэг үйл ажиллагаа хэрэгжүүлэх асуудал.

9/Сангийн сайд:

-төсвийн бодлого, төсөв, санхүү, эдийн засгийн судалгаа, төсөөлөл;

-санхүүгийн зах зээл, төсвийн орлого, зарлага, өрийн удирдлагын асуудал;

-нэгдсэн төсвийн талаарх судалгаа, төлөвлөлт, нэгдсэн төсвийг улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөнд нийцүүлэн боловсруулах асуудал;

-төсвийн хөрөнгө оруулалтын бодлого, зохицуулалт, санхүүжилтийн үйл ажиллагаа;

-улсын болон орон нутгийн төсвийн зарцуулалтын хяналт;  
-зээл, тусламжийн асуудал;  
-нягтлан бодох бүртгэлийн бодлого;  
-гаалийн бодлого;  
-татварын бодлого;  
-даатгалын бодлого;  
-төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах бодлого;

-төр, хувийн хэвшлийн түншлэлийн төсөв, санхүүгийн удирдлага болон хяналт;



асуудал. -төрийн үйл ажиллагааны ил тод байдлыг хангах асуудал;  
-агаарын бохирдлын эсрэг үйл ажиллагаа хэрэгжүүлэх

10/Хууль зүй, дотоод хэргийн сайд:

асургалт, сурталчилгаа, судалгаа; -эрх зүйн шинэтгэлийн бодлого;  
-хууль тогтоомжийн системчлэл, мэдээлэл, эрх зүйн

тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх асуудал; -эрх зүйн туслалцаа;  
-улсын хил хамгааллын асуудал;  
-цагдаа, нийгмийн дэг журам сахиулах, гэмт хэрэгтэй

хуульчдын олон нийтийн байгууллагатай харилцах асуудал; -шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа;  
-Засгийн газраас шүүх, прокурорын байгууллага,

суух гадаадын иргэний асуудал; -төрөөс сүм хийдтэй харилцах асуудал;  
-иргэний харьяалал, цагаачлалын асуудал;  
-энгийн зэргийн виз, Монгол Улсад орох, гарах, оршин

зүйн үндэслэлийн хяналт; -төрийн захиргааны байгууллагын шийдвэрийн хууль

бүртгэл; -иргэн, хуулийн этгээд, эд хөрөнгийн эрхийн улсын

хөтөлбөрийг дэмжин хэрэгжүүлэх; -хэвлэл, мэдээллийн хэрэгслийн бүртгэл;  
-архивын талаар төрөөс баримтлах бодлого;  
-иргэний боловсролын албан болон албан бус

асуудал. -төрийн үйл ажиллагааны ил тод байдлыг хангах асуудал;  
-агаарын бохирдлын эсрэг үйл ажиллагаа хэрэгжүүлэх

11/Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд:

нөөцийн талаарх бодлого; -хүнд үйлдвэрлэлийн асуудал;  
-үйлдвэрлэл, технологийн паркийн асуудал;  
-геологи, эрдэс баялгийн бодлого;  
-геологийн эрэл, хайгуул, судалгааны зохицуулалт;  
-газрын тос, газрын тосны бүтээгдэхүүн болон түүний



-цацраг идэвхт ашигт малтмал болон цөмийн энерги ашиглах асуудал;

- олборлох үйлдвэрийн техник, технологийн асуудал;
- ил тод, хариуцлагатай уул уурхайг хөгжүүлэх бодлого;
- эрдэс баялаг болон хүнд үйлдвэрийн бүтээгдэхүүний

экспорт, импортын асуудал;

асуудал.  
-салбарын мэргэжлийн хяналтын асуудал;  
-төрийн үйл ажиллагааны ил тод байдлыг хангах асуудал;  
-агаарын бохирдлын эсрэг үйл ажиллагаа хэрэгжүүлэх

12/Батлан хамгаалахын сайд:

асуудал;  
-улсыг батлан хамгаалах бодлого болон цэргийн бодлого;  
-зэвсэгт хүчнийг чадваржуулах бодлого;  
-энхийг дэмжих ажиллагаанд оролцох бэлтгэл хангуулах

асуудал.  
-төрийн үйл ажиллагааны ил тод байдлыг хангах асуудал;  
-агаарын бохирдлын эсрэг үйл ажиллагаа хэрэгжүүлэх

13/Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд:

сэргээх болон экологийн бодлого;  
-ногоон хөгжлийн бодлого;  
-байгаль орчныг хамгаалах, зохистой ашиглах, нөхөн

асуудал;  
-усны нэгдсэн бодлого;  
-цөлжилттэй тэмцэх болон ойжуулалтын асуудал;  
-усны нөөцийг нэмэгдүүлэх, ашиглалтыг сайжруулах

мэдээллийн сан;  
-ургамал, ан амьтны нөөцийг хамгаалах асуудал,  
-байгаль орчны шинжилгээ, ус, цаг уур болон байгалийн болзошгүй гамшгаас урьдчилан сэргийлэх, экологийн аюулгүй байдлыг хангах асуудал;

асуудал.  
-биоаюулгүй байдлын бодлогын асуудал;  
-салбарын мэргэжлийн хяналтын асуудал;  
-төрийн үйл ажиллагааны ил тод байдлыг хангах асуудал;  
-агаарын бохирдлын эсрэг үйл ажиллагаа хэрэгжүүлэх

14/Боловсролын сайд:



-боловсролын тогтолцоог хөгжүүлэх асуудал;  
-ном хэвлэл, цахим бичвэрийн бодлого;  
-салбарын үйлдвэрлэл, үйлчилгээ, ажлын байрыг нэмэгдүүлэх асуудал;

-мэргэжлийн боловсрол, сургалтын тогтолцоог хөгжүүлэх асуудал;  
-зэргийн болон мэргэжлийн боловсролыг хөдөлмөрийн зах зээлтэй уялдуулах;

-салбарын мэргэжлийн хяналтын асуудал;  
-төрийн үйл ажиллагааны ил тод байдлыг хангах асуудал;  
-агаарын бохирдлын эсрэг үйл ажиллагаа хэрэгжүүлэх асуудал.

15/Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд:

-хүн амын хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудал;  
-хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх, ажилгүйдлийг багасгах, ядуурлыг бууруулах бодлого;

-гэр бүл, хүүхэд, ахмад настан болон хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөгжил, нийгмийн хамгааллын асуудал;

-нийгмийн халамжийн бодлого;  
-нийгмийн даатгалын бодлого;  
-хөдөлмөрийн нөхцөл, хөдөлмөрийн аюулгүй байдал, ажиллагчдын цалин, амьдралын өртгийн талаарх асуудал;

-хөдөлмөрийн биржийн асуудал;  
-хөдөлмөрийн зах зээлийн зохицуулалт;  
-хөдөлмөрийн харилцаа, Засгийн газар, эзэд, Үйлдвэрчний эвлэлийн гурван талт түншлэл, хөдөлмөрийн хамтын маргааны зохицуулалтын асуудал;

-Монгол Улсад хөдөлмөр эрхэлж байгаа гадаадын иргэний асуудал;

-гадаадад ажиллах хүч гаргах асуудал;  
-салбарын мэргэжлийн хяналтын асуудал;  
-төрийн үйл ажиллагааны ил тод байдлыг хангах асуудал;  
-агаарын бохирдлын эсрэг үйл ажиллагаа хэрэгжүүлэх асуудал.

16/Зам, тээврийн сайд:



-авто замын асуудал;  
-авто тээврийн асуудал;  
-төмөр замын тээврийн асуудал;  
-иргэний нисэхийн асуудал;  
-далай ашиглах болон усан замын тээврийн асуудал;  
-тээврийн тогтолцоог хөгжүүлэх бодлого, зохицуулалт;  
-салбарын үйлдвэрлэл, үйлчилгээ, ажлын байрыг нэмэгдүүлэх асуудал;

-салбарын мэргэжлийн хяналтын асуудал;  
-төрийн үйл ажиллагааны ил тод байдлыг хангах асуудал;  
-агаарын бохирдлын эсрэг үйл ажиллагаа хэрэгжүүлэх асуудал.

17/Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайд:

-аялал жуулчлалын бодлого;  
-соёл, урлагийг хөгжүүлэх асуудал;  
-түүх, соёлын өвийг хамгаалах, сэргээх бодлого;  
-биеийн тамир, спортыг хөгжүүлэх бодлого;  
-мэргэжлийн спортын хөгжлийн асуудал;  
-үндэсний уламжлалт спортыг дэмжих, хөгжүүлэх бодлого;  
-залуучуудын хөгжил, оролцоог дэмжих бодлого;  
-салбарын үйлдвэрлэл, үйлчилгээ, ажлын байрыг нэмэгдүүлэх асуудал;

-салбарын мэргэжлийн хяналтын асуудал;  
-төрийн үйл ажиллагааны ил тод байдлыг хангах асуудал;  
-агаарын бохирдлын эсрэг үйл ажиллагаа хэрэгжүүлэх асуудал.

18/Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайд:

-хот төлөвлөлт болон хот байгуулалтын бодлого, архитектурын асуудал;

-барилга, барилгын материалын үйлдвэрлэлийн бодлого;  
-орон сууцны бодлого;  
-нийтийн аж ахуйн асуудал;  
-салбарын үйлдвэрлэл, үйлчилгээ, ажлын байрыг нэмэгдүүлэх асуудал;

-салбарын мэргэжлийн хяналтын асуудал;  
-төрийн үйл ажиллагааны ил тод байдлыг хангах асуудал;



асуудал.

-агаарын бохирдлын эсрэг үйл ажиллагаа хэрэгжүүлэх

19/Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд:

-хүн амын хүнсний хангамжийн бодлого;  
-хүнсний аюулгүй байдлын асуудал;  
-мал аж ахуйг эрчимжүүлэн хөгжүүлэх бодлого;  
-газар тариаланг эрчимжүүлэн хөгжүүлэх бодлого;  
-мал эмнэлэг, малын үржлийн талаар төрөөс явуулах

бодлого;

-мал, амьтан, ургамлын хорио, цээрийн асуудал;  
-бэлчээрийн болон таримал ургамлыг хамгаалах асуудал;  
-мал, таримал ургамлын гаралтай хүнсний зүйл, түүхий  
эд болон хөнгөн үйлдвэрийн бүтээгдэхүүний экспорт, импортын асуудал;

асуудал.

-хөдөө аж ахуйн эдэлбэр газрын болон бэлчээр  
ашиглалтын бодлого;

-малыг цаг агаарын гэнэтийн аюулаас хамгаалах бодлого;  
-хөнгөн үйлдвэрлэлийн асуудал;  
-жижиг, дунд үйлдвэрийн асуудал;  
-дотоод худалдаа, үйлчилгээний бодлого, зохицуулалт;  
-үйлдвэрлэл, технологийн паркийн асуудал;  
-салбарын мэргэжлийн хяналтын асуудал;  
-төрийн үйл ажиллагааны ил тод байдлыг хангах асуудал;  
-агаарын бохирдлын эсрэг үйл ажиллагаа хэрэгжүүлэх

асуудал.

20/Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайд:

-харилцаа холбоо, сансар, мэдээллийн технологи, өргөн  
нэвтрүүлэг, шуудангийн бодлого, зохицуулалт;

-цахим засаглал, салбарын хөгжлийг мэдээллийн  
технологиор дэмжих асуудал;

-өндөр технологи, үндэсний инновацын тогтолцооны  
бодлого, төлөвлөлт, хөгжүүлэх асуудал;

асуудал.

-радио давтамжийн бодлого;  
-бүх нийтийн үйлчилгээний үүргийн талаарх бодлого,  
зохицуулалт;

-нийтийн мэдээллийн дэд бүтцийн асуудал;  
-харилцаа холбоо, мэдээллийн технологийн салбарын  
инновацыг хөгжүүлэх асуудал;



-кибер аюулгүй байдлын бодлого, зохицуулалт;  
-цахим орчинд хүний хувийн мэдээлэл хамгаалах бодлого, зохицуулалт;

-мэдээллийн технологийн салбарын хүний нөөцийн хөгжил, тогтвортой хөдөлмөр эрхлэлтийг дэмжих асуудал;

-төрийн үйлчилгээг хүртээмжтэй, нэгдсэн байдлаар хүргэх бодлого, зохицуулалт;

-салбарын мэргэжлийн хяналтын асуудал;  
-төрийн үйл ажиллагааны ил тод байдлыг хангах асуудал;  
-агаарын бохирдлын эсрэг үйл ажиллагаа хэрэгжүүлэх асуудал.

#### 21/Эрчим хүчний сайд:

-эрчим хүчний нэгдсэн бодлого;  
-эрчим хүчний үйлдвэрлэлт, дамжуулалт, түгээлтийн асуудал;

-сэргээгдэх эрчим хүчийг хөгжүүлэх асуудал;  
-эрчим хүчний шинэ эх үүсвэрийг бий болгох, ашиглах бодлого;

-түлшний хангамж, нөөцийн бодлого, зохицуулалт;  
-эрчим хүч хэмнэлтийн бодлого;  
-эрчим хүчний нүүрсний асуудал;  
-салбарын үйлдвэрлэл, үйлчилгээ, ажлын байрыг нэмэгдүүлэх асуудал;

-салбарын мэргэжлийн хяналтын асуудал;  
-төрийн үйл ажиллагааны ил тод байдлыг хангах асуудал;  
-агаарын бохирдлын эсрэг үйл ажиллагаа хэрэгжүүлэх асуудал.

#### 22/Эрүүл мэндийн сайд:

-хүн амын эрүүл мэндийг хамгаалах, нөхөн сэргээх бодлого;

-эм, эмнэлгийн хэрэгсэл, техникийн үйлдвэрлэл, хангамжийн талаарх бодлого;

-эмнэлгийн үйлчилгээ, эрүүл ахуй, халдвар судлалын хүрээний бодлого;

-хүн амын эрүүл мэндийг хамгаалах, нийгмийн болон мэргэжлийн арга хэмжээ;

-салбарын үйлдвэрлэл, үйлчилгээ, ажлын байрыг нэмэгдүүлэх асуудал;

- эрүүл мэндийн даатгалын бодлого, зохицуулалт;
- салбарын мэргэжлийн хяналтын асуудал;
- төрийн үйл ажиллагааны ил тод байдлыг хангах асуудал;
- агаарын бохирдлын эсрэг үйл ажиллагаа хэрэгжүүлэх

асуудал.”

**2 дугаар зүйл.**Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн “Ерөнхий сайдын түр эзгүйд түүний үүргийг Монгол Улсын Шадар сайд гүйцэтгэнэ. Ерөнхий сайд, Шадар сайд нэгэн зэрэг түр эзгүй байх тохиолдолд Ерөнхий сайдын үүрэг болгосноор Засгийн газрын аль нэг гишүүн Ерөнхий сайдын үүргийг гүйцэтгэнэ” гэснийг “Ерөнхий сайдын түр эзгүйд түүний үүргийг Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд гүйцэтгэнэ. Ерөнхий сайд, Тэргүүн шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд нэгэн зэрэг түр эзгүй байх тохиолдолд Ерөнхий сайдын үүрэг болгосноор аль нэг Шадар сайд Ерөнхий сайдын үүргийг гүйцэтгэнэ” гэж, 18<sup>3</sup> дугаар зүйлийн 1 дэх хэсгийн “хилийн боомтын, олимп, нийтийн биеийн тамир, спортын болон нийслэл Улаанбаатар хотын авто замын түгжрэлийг бууруулах” гэснийг “хяналт, үнэлгээний, 20 минутын хот болон боомтын сэргэлтийн” гэж, 20 дугаар зүйлийн 6 дахь хэсгийн “Шадар сайдын түр эзгүйд түүний үүргийг Шадар сайдын саналыг үндэслэн Ерөнхий сайдын үүрэг болгосон Засгийн газрын аль нэг гишүүн гүйцэтгэх бөгөөд ийнхүү Шадар сайдын” гэснийг “Тэргүүн шадар сайд, Шадар сайдын түр эзгүйд түүний үүргийг Тэргүүн шадар сайд, Шадар сайдын саналыг үндэслэн Ерөнхий сайдын үүрэг болгосон Засгийн газрын аль нэг гишүүн гүйцэтгэх бөгөөд ийнхүү Тэргүүн шадар сайд, Шадар сайдын” гэж тус тус өөрчилсүгэй.

**3 дугаар зүйл.**Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 12 дахь заалтыг хүчингүй болсонд тооцсугай.

**4 дүгээр зүйл.**Энэ хуулийг 2024 оны 07 дугаар сарын 10-ны өдөр баталсан Засгийн газрын бүтцийн тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**Д.АМАРБАЯСГАЛАН**



**Мөрдөгч Фолд\_02 Нөдөл**

Хяналтын үйлчилгээний байр

2024 оны 06 сарын 28 өдөр

Хяналтын үйлчилгээний байр  
Хяналтын үйлчилгээний байр  
Хяналтын үйлчилгээний байр

Хяналтын үйлчилгээний байр... Хяналтын үйлчилгээний байр...  
Хяналтын үйлчилгээний байр... Хяналтын үйлчилгээний байр...  
Хяналтын үйлчилгээний байр... Хяналтын үйлчилгээний байр...

Хяналтын үйлчилгээний байр

«Хяналтын үйлчилгээний байр...»

Хяналтын үйлчилгээний байр

Хяналтын үйлчилгээний байр

Хяналтын үйлчилгээний байр

Хяналтын үйлчилгээний байр

Хяналтын үйлчилгээний байр

Хяналтын үйлчилгээний байр

Хяналтын үйлчилгээний байр

Хяналтын үйлчилгээний байр

Хяналтын үйлчилгээний байр

Хяналтын үйлчилгээний байр

Хяналтын үйлчилгээний байр

Хяналтын үйлчилгээний байр

































## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2024 оны 07 дугаар  
сарын 10-ны өдөр

Улаанбаатар  
хот

### ЗАСГИЙН ГАЗРЫН БҮТЦИЙН ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Засгийн газрын бүтцэд доор дурдсан яам ажиллана:

Ерөнхий чиг үүргийн:

- 1/Эдийн засаг, хөгжлийн яам;
- 2/Гадаад харилцааны яам;
- 3/Сангийн яам;
- 4/Хууль зүй, дотоод хэргийн яам;

Чиглэлийн:

- 5/Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам;
- 6/Батлан хамгаалах яам;
- 7/Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам;
- 8/Боловсролын яам;
- 9/Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам;
- 10/Зам, тээврийн яам;
- 11/Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яам;
- 12/Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яам;
- 13/Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам;
- 14/Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яам;
- 15/Эрчим хүчний яам;
- 16/Эрүүл мэндийн яам.

**2 дугаар зүйл.** Энэ хуулийг 2024 оны 07 дугаар сарын 10-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА

Д.АМАРБАЯСГАЛАН



**Мэдээлэл ба мэдээлэл**

2024 оны 12 сарын 28-ны өдөр

МОНГОЛЫН ХӨГЖИЛ

МОНГОЛЫН ХӨГЖИЛ

МОНГОЛЫН ХӨГЖИЛ

МОНГОЛЫН ХӨГЖИЛ

МОНГОЛЫН ХӨГЖИЛ

МОНГОЛЫН ХӨГЖИЛ

МОНГОЛЫН ХӨГЖИЛ

МОНГОЛЫН ХӨГЖИЛ

МОНГОЛЫН ХӨГЖИЛ

МОНГОЛЫН ХӨГЖИЛ

МОНГОЛЫН ХӨГЖИЛ

МОНГОЛЫН ХӨГЖИЛ

МОНГОЛЫН ХӨГЖИЛ

МОНГОЛЫН ХӨГЖИЛ

МОНГОЛЫН ХӨГЖИЛ

МОНГОЛЫН ХӨГЖИЛ

МОНГОЛЫН ХӨГЖИЛ

МОНГОЛЫН ХӨГЖИЛ

МОНГОЛЫН ХӨГЖИЛ

МОНГОЛЫН ХӨГЖИЛ

МОНГОЛЫН ХӨГЖИЛ

МОНГОЛЫН ХӨГЖИЛ

МОНГОЛЫН ХӨГЖИЛ



## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2024 оны 07 дугаар  
сарын 10-ны өдөр

Улаанбаатар  
хот

### ЗАСГИЙН ГАЗРЫН БҮРЭЛДЭХҮҮНИЙ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Засгийн газрын бүрэлдэхүүнийг доор дурдсанаар тогтоосугай:

1/Монгол Улсын Ерөнхий сайд;

2/Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд;

3/Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Монгол Улсын Шадар сайд;

4/Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Монгол Улсын Шадар сайд;

5/Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга;

6/Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Монгол Улсын сайд, Хяналт, үнэлгээний Үндэсний хорооны дарга;

7/Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Монгол Улсын сайд, Боомтын сэргэлтийн Үндэсний хорооны дарга;

8/Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Монгол Улсын сайд, 20 минутын хот Үндэсний хорооны дарга;

9/Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Гадаад харилцааны сайд;

10/Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Сангийн сайд;

11/Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Хууль зүй, дотоод хэргийн сайд;

12/Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд;

13/Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Батлан хамгаалахын сайд;

14/Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд;



15/Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Боловсролын сайд;

16/Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд;

17/Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Зам, тээврийн сайд;

18/Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайд;

19/Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайд;

20/Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд;

21/Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайд;

22/Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Эрчим хүчний сайд;

23/Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Эрүүл мэндийн сайд.

**2 дугаар зүйл.**Энэ хуулийг 2024 оны 07 дугаар сарын 10-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**Д.АМАРБАЯСГАЛАН**



МОНГОЛЫН  
МОНГОЛЫН  
МОНГОЛЫН

МОНГОЛЫН  
МОНГОЛЫН  
МОНГОЛЫН

МОНГОЛЫН  
МОНГОЛЫН  
МОНГОЛЫН

МОНГОЛЫН  
МОНГОЛЫН  
МОНГОЛЫН

МОНГОЛЫН  
МОНГОЛЫН  
МОНГОЛЫН

МОНГОЛЫН  
МОНГОЛЫН  
МОНГОЛЫН

МОНГОЛЫН  
МОНГОЛЫН  
МОНГОЛЫН

МОНГОЛЫН  
МОНГОЛЫН  
МОНГОЛЫН

МОНГОЛЫН  
МОНГОЛЫН  
МОНГОЛЫН

МОНГОЛЫН  
МОНГОЛЫН  
МОНГОЛЫН

МОНГОЛЫН  
МОНГОЛЫН  
МОНГОЛЫН

МОНГОЛЫН  
МОНГОЛЫН  
МОНГОЛЫН

МОНГОЛЫН  
МОНГОЛЫН  
МОНГОЛЫН

МОНГОЛЫН  
МОНГОЛЫН  
МОНГОЛЫН

МОНГОЛЫН  
МОНГОЛЫН  
МОНГОЛЫН

МОНГОЛЫН  
МОНГОЛЫН  
МОНГОЛЫН

МОНГОЛЫН  
МОНГОЛЫН  
МОНГОЛЫН







## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2024 оны 07 дугаар  
сарын 10-ны өдөр

Улаанбаатар  
хот

### МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН БҮТЦИЙН ТУХАЙ ХУУЛЬ ХҮЧИНГҮЙ БОЛСОНД ТООЦОХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** 2016 оны 7 дугаар сарын 21-ний өдөр баталсан Монгол Улсын Засгийн газрын бүтцийн тухай хуулийг хүчингүй болсонд тооцогуй.

**2 дугаар зүйл.** Энэ хуулийг 2024 оны 07 дугаар сарын 10-ны өдөр баталсан Засгийн газрын бүтцийн тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА

Д.АМАРБАЯСГАЛАН

Монгол Улсын  
Их Хурлын  
Дарга

Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, Төрийн захиргааны  
эргэлтний 10-ны өдөр 2024 оны 07 дугаар сарын 10

МОНГОЛ УЛСЫН  
ЗАСГИЙН ГАЗРЫН  
БҮТЦИЙН ТУХАЙ  
ХУУЛЬ

Энэ хууль 2024 оны 07 дугаар сарын 10-ны өдөр  
Монгол Улсын Засгийн газрын бүтцийн тухай хуулийг  
хүчингүй болсонд тооцох тухай хууль болсон өдрөөс  
эхлэн дагаж мөрдөнө.

Энэ хууль 2024 оны 07 дугаар сарын 10-ны өдөр  
Монгол Улсын Засгийн газрын бүтцийн тухай хууль  
хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА

Д.АМАРБАЯСГАЛАН



## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2024 оны 07 дугаар  
сарын 10-ны өдөр

Улаанбаатар  
хот

### МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН БҮРЭЛДЭХҮҮНИЙ ТУХАЙ ХУУЛЬ ХҮЧИНГҮЙ БОЛСОНД ТООЦОХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** 2016 оны 7 дугаар сарын 21-ний өдөр баталсан Монгол Улсын Засгийн газрын бүрэлдэхүүний тухай хуулийг хүчингүй болсонд тооцугай.

**2 дугаар зүйл.** Энэ хуулийг 2024 оны 07 дугаар сарын 10-ны өдөр баталсан Засгийн газрын бүтцийн тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА

Д.АМАРБАЯСГАЛАН

Монгол Улсын  
Их Хурлын  
Дарга

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН БҮРЭЛДЭХҮҮНИЙ ТУХАЙ ХУУЛЬ

Хүчин төгөлдөр болсон өдөр  
2024 оны 07 сарын 10

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН БҮРЭЛДЭХҮҮНИЙ ТУХАЙ ХУУЛЬ  
ХҮЧИНГҮЙ БОЛСОНД ТООЦОХ ТУХАЙ

Энэ хуулийг 2024 оны 07 сарын 10-ны өдөр баталсан  
Засгийн газрын бүтцийн тухай хууль хүчин төгөлдөр болсон  
өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА

Д.АМАРБАЯСГАЛАН



## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2024 оны 07 дугаар  
сарын 10-ны өдөр

Улаанбаатар  
хот

**ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ  
ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.** Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1.9 дэх заалтын “нийслэл Улаанбаатар хотын авто замын түгжрэлийг бууруулах” гэснийг “20 минутын хотын” гэж, 14.1.10 дахь заалтын “олимп, нийтийн биеийн тамир, спортын” гэснийг “хяналт, үнэлгээний” гэж, 16 дугаар зүйлийн 16.4.3 дахь заалтын “нийслэл Улаанбаатар хотын авто замын түгжрэлийг бууруулах асуудал эрхэлсэн сайдын, олимп, нийтийн биеийн тамир, спортын асуудал эрхэлсэн сайдын” гэснийг “20 минутын хотын асуудал эрхэлсэн сайдын, хяналт, үнэлгээний асуудал эрхэлсэн сайдын” гэж тус тус өөрчилсүгэй.

**2 дугаар зүйл.** Энэ хуулийг 2024 оны 07 дугаар сарын 10-ны өдөр баталсан Засгийн газрын бүтцийн тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА

Д.АМАРБАЯСГАЛАН





## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2024 оны 07 дугаар  
сарын 10-ны өдөр

Улаанбаатар  
хот

### ЗАСГИЙН ГАЗАР ДАХЬ ХЯНАЛТЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.**Засгийн газар дахь хяналтын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.3 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“16.3.Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх газрын дарга нь Ерөнхий хянан шалгагч байна.”

**2 дугаар зүйл.**Засгийн газар дахь хяналтын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.2 дахь заалтын “Монгол Улсын сайд-Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргаас” гэснийг “Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Монгол Улсын сайд, Хяналт, үнэлгээний Үндэсний хорооны даргаас” гэж, 11 дүгээр зүйлийн гарчгийн, 11 дүгээр зүйлийн 11.1, 11.3 дахь хэсгийн, 16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсгийн “Монгол Улсын сайд-Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын” гэснийг “Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Монгол Улсын сайд, Хяналт, үнэлгээний Үндэсний хорооны даргын” гэж, 11 дүгээр зүйлийн 11.2 дахь хэсгийн, 17 дугаар зүйлийн 17.1.7 дахь заалтын, 19 дүгээр зүйлийн 19.1, 19.3 дахь хэсгийн “Монгол Улсын сайд-Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргад” гэснийг “Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Монгол Улсын сайд, Хяналт, үнэлгээний Үндэсний хорооны даргад” гэж, 18 дугаар зүйлийн 18.6 дахь хэсгийн “Монгол Улсын сайд-Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга” гэснийг “Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Монгол Улсын сайд, Хяналт, үнэлгээний Үндэсний хорооны дарга” гэж тус тус өөрчилсүгэй.

**3 дугаар зүйл.**Засгийн газар дахь хяналтын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.6 дахь хэсгийг хүчингүй болсонд тооцсугай.

**4 дүгээр зүйл.**Энэ хуулийг 2024 оны 07 дугаар сарын 10-ны өдөр баталсан Засгийн газрын бүтцийн тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА

Д.АМАРБАЯСГАЛАН





## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2024 оны 07 дугаар  
сарын 10-ны өдөр

Улаанбаатар  
хот

### ӨРСӨЛДӨӨНИЙ ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Өрсөлдөөний тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.5, 6.7 дахь хэсгийн, 8 дугаар зүйлийн 8.2, 8.3 дахь хэсгийн, 14 дүгээр зүйлийн гарчгийн, 14.1, 14.3, 14.6, 14.7, 14.10, 14.11 дэх хэсгийн, 15 дугаар зүйлийн 15.1 дэх хэсгийн, 17 дугаар зүйлийн 17.1 дэх хэсгийн, 24 дүгээр зүйлийн 24.2, 24.4 дэх хэсгийн, 26 дугаар зүйлийн 26.1.1 дэх заалтын “Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газар” гэснийг “Монополын эсрэг газар” гэж, 6 дугаар зүйлийн 6.4 дэх хэсгийн, 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсгийн, 11 дүгээр зүйлийн 11.4 дэх хэсгийн, 14 дүгээр зүйлийн 14.4 дэх хэсгийн, 26 дугаар зүйлийн 26.1.3 дахь заалтын “Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газарт” гэснийг “Монополын эсрэг газарт” гэж, 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсгийн, Гуравдугаар бүлгийн гарчгийн, 14 дүгээр зүйлийн 14.2, 14.5, 14.8, 14.9, 14.10, 14.12, 14.13 дахь хэсгийн, 15 дугаар зүйлийн гарчгийн, 16 дугаар зүйлийн гарчгийн, 16.1, 16.3, 16.5, 16.7 дахь хэсгийн, 17 дугаар зүйлийн гарчгийн, 17.2, 17.3, 17.4, 17.5 дахь хэсгийн, 18 дугаар зүйлийн гарчгийн, 18.1, 18.2 дахь хэсгийн, 19 дүгээр зүйлийн гарчгийн, 19.1, 19.2 дахь хэсгийн, 21 дүгээр зүйлийн гарчгийн, 21.1, 21.2 дахь хэсгийн, 23 дугаар зүйлийн 23.2, 23.4 дэх хэсгийн, 25 дугаар зүйлийн 25.2 дахь хэсгийн, 26 дугаар зүйлийн 26.2 дахь хэсгийн “Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газрын” гэснийг “Монополын эсрэг газрын” гэж, 10 дугаар зүйлийн 10.1 дэх хэсгийн, 20 дугаар зүйлийн 20.1 дэх хэсгийн, 20.3.5 дахь заалтын “Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газраас” гэснийг “Монополын эсрэг газраас” гэж тус тус өөрчилсүгэй.

**2 дугаар зүйл.** Энэ хуулийг 2024 оны 07 дугаар сарын 10-ны өдөр баталсан Засгийн газрын бүтцийн тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА

Д.АМАРБАЯСГАЛАН











## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2024 оны 07 дугаар  
сарын 10-ны өдөр

Улаанбаатар  
хот

### БҮСЧИЛСЭН ХӨГЖЛИЙН УДИРДЛАГА ЗОХИЦУУЛАЛТЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Бүсчилсэн хөгжлийн удирдлага зохицуулалтын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.6 дахь хэсгийн “дүрэм,” гэсний дараа “Ажлын албаны” гэж нэмсүгэй.

**2 дугаар зүйл.** Бүсчилсэн хөгжлийн удирдлага зохицуулалтын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3 дахь хэсгийн, 7 дугаар зүйлийн 7.4 дэх хэсгийн “үндэсний хөгжлийн бодлого, төлөвлөлтийн” гэснийг “бүсчилсэн хөгжлийн” гэж, мөн зүйлийн 7.6 дахь хэсгийн, 13 дугаар зүйлийн гарчгийн, мөн зүйлийн 13.1 дэх хэсгийн “Үндэсний хөгжлийн бодлого, төлөвлөлтийн” гэснийг “Бүсчилсэн хөгжлийн” гэж, 8 дугаар зүйлийн 8.1.2, 8.1.8 дахь заалтын “бүс нутгийн хөгжлийн” гэснийг “эдийн засаг, хөгжлийн” гэж тус тус өөрчилсүгэй.

**3 дугаар зүйл.** Бүсчилсэн хөгжлийн удирдлага зохицуулалтын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.5 дахь хэсгийн “Ажлын албаны үүргийг үндэсний хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын холбогдох нэгж хэрэгжүүлнэ.” гэснийг хассугай.

**4 дүгээр зүйл.** Энэ хуулийг 2024 оны 07 дугаар сарын 10-ны өдөр баталсан Засгийн газрын бүтцийн тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА

Д.АМАРБАЯСГАЛАН

Индрига Фола на Холл

2024 оны 06 сарын 09 өдөр

Улаанбаатар

Хүндэтгэсэн /Хүндэтгэсэн/ .  
Хүндэтгэсэн /Хүндэтгэсэн/ .  
Хүндэтгэсэн /Хүндэтгэсэн/ .

«...»-ийн үндсэн зарчмууд нь «...»-ийн үндсэн зарчмуудтай адилтгахад зориулагдсан байна. Энэ нь «...»-ийн үндсэн зарчмуудтай адилтгахад зориулагдсан байна.

1. Энэ үндсэн зарчмууд нь «...»-ийн үндсэн зарчмуудтай адилтгахад зориулагдсан байна. Энэ нь «...»-ийн үндсэн зарчмуудтай адилтгахад зориулагдсан байна.

2. Энэ үндсэн зарчмууд нь «...»-ийн үндсэн зарчмуудтай адилтгахад зориулагдсан байна. Энэ нь «...»-ийн үндсэн зарчмуудтай адилтгахад зориулагдсан байна.

3. Энэ үндсэн зарчмууд нь «...»-ийн үндсэн зарчмуудтай адилтгахад зориулагдсан байна. Энэ нь «...»-ийн үндсэн зарчмуудтай адилтгахад зориулагдсан байна.

Хүндэтгэсэн /Хүндэтгэсэн/

Хүндэтгэсэн /Хүндэтгэсэн/



## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2024 оны 05 дугаар  
сарын 16-ны өдөр

Дугаар 46

Улаанбаатар  
хот

### Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө батлах тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэг, Авлигын эсрэг хуулийн 2<sup>1</sup> дүгээр зүйлийн 2<sup>1.1</sup> дэх хэсэг, Улсын Их Хурлын 2023 оны 59 дүгээр тогтоолыг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.“Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-г хавсралтаар баталсугай.

2.Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээг тогтоосон хугацаанд хэрэгжүүлж, хэрэгжилтийг жил бүрийн 02 дугаар сарын 01-ний өдрийн дотор Засгийн газрын Хэрэг эрхлэх газар болон Авлигатай тэмцэх газарт тус тус тайлагнаж ажиллахыг Засгийн газрын гишүүд, агентлаг, аймаг, нийслэлийн Засаг дарга, иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга, Улсын дээд шүүх, Улсын ерөнхий прокурорын газар, Шүүхийн ерөнхий зөвлөл, Шүүхийн сахилгын хороо, Улсын Их Хуралд ажлаа шууд хариуцан тайлагнадаг байгууллага, төрийн болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн удирдлагад тус тус даалгаж, Монголын үндэсний худалдаа, аж үйлдвэрийн танхим, иргэний нийгэм, хэвлэл мэдээллийн байгууллагад зөвлөсүгэй.

3.Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хороо /Д.Цогтбаатар/-нд даалгасугай.

МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА

Г.ЗАНДАНШАТАР





































Боловсролын Төвлөлийн Төлөвлөгөө 2024	Зорилго, зорилт, үйл дэмжлэг	Арга хэмжээ	Шатруур уугаагүй Төлөвлөгөө	Зорилт үүснэгт							Мэдээллийн үзүүлэлт	Мэдээллийн үзүүлэлт чулуулга өгөх сурвалж	Мэдээллийн үзүүлэлт чулуулга өгөх дөнгө	Шалгаруулах Хөдөлгөөн байгууллага	Шалгаруулах Хөдөлгөөн байгууллага (бас төрийн)	Саямжуулалт Саямжуулах Хөдөлгөөн (бас төрийн)	Мэдээллийн үзүүлэлт Хөдөлгөөн байгууллага	Хамтран хариуцагч
				Он	Тусуудын 2024	2025	2026	2027	2028	2029								
3.3. 3.3.1. 3.3.1.1. 3.3.1.2. 3.3.1.3.	Зорилт 3.3.1-ийн үйл ажиллагаа хэрэгт бус мөчлөгийн хяналт тэмцэв, өргөтгөл өргөтгөл, өргөтгөл байгууллага болж үлдсэн болгоно.	Арга хэмжээ Төрийн үйл ажиллагаа хэрэгт бус мөчлөгийн хяналт тэмцэв, өргөтгөл өргөтгөл, өргөтгөл байгууллага болж үлдсэн болгоно.	Шатруур уугаагүй Төлөвлөгөө	2023	-	-	-	-	-	-	-	30	Алслагдсан Төрийн үйл ажиллагаа байгууллага	Алслагдсан Төрийн үйл ажиллагаа байгууллага	Улаанбаатар Улаанбаатар Улаанбаатар	Улаанбаатар Төрийн үйл ажиллагаа байгууллага	Хамтран хариуцагч	
3.3.1.1.	3.3.1.1. Иргэдийн нийгмийн байгууллагын эрх үйл ажиллагааг зохицуулах, хуульчилсан байгууллагын төлөөллийн тоог нэмэгдүүлэх	Хуулийн алдрын хэрэгт бус мөчлөгийн хяналт тэмцэв, өргөтгөл, өргөтгөл байгууллага болж үлдсэн болгоно.	Шатруур уугаагүй Төлөвлөгөө	2023	-	5	10	20	-	-	-	30	Алслагдсан Төрийн үйл ажиллагаа байгууллага	Алслагдсан Төрийн үйл ажиллагаа байгууллага	Улаанбаатар Улаанбаатар	Улаанбаатар Төрийн үйл ажиллагаа байгууллага	Хамтран хариуцагч	
3.3.1.2.	3.3.1.2. Иргэдийн нийгмийн байгууллагын эрх үйл ажиллагааг зохицуулах, хуульчилсан байгууллагын төлөөллийн тоог нэмэгдүүлэх	Иргэдийн нийгмийн байгууллагын эрх үйл ажиллагааг зохицуулах, хуульчилсан байгууллагын төлөөллийн тоог нэмэгдүүлэх	Шатруур уугаагүй Төлөвлөгөө	2022	-	-	4	-	-	-	4	-	Хууль зүй, дотоод, хөдөлгөөн байгууллага	Хууль зүй, дотоод, хөдөлгөөн байгууллага	Улаанбаатар Улаанбаатар	Улаанбаатар Төрийн үйл ажиллагаа байгууллага	Хамтран хариуцагч	
3.3.1.3.	3.3.1.3. Иргэдийн нийгмийн байгууллагын таларх эрх зүйн зохицуулалтыг сайжруулах	Төрийн өргөөнт байгууллагын эрх үйл ажиллагааг зохицуулах, хуульчилсан байгууллагын төлөөллийн тоог нэмэгдүүлэх	Шатруур уугаагүй Төлөвлөгөө	2023	1	-	1	-	-	-	-	-	Хууль зүй, дотоод, хөдөлгөөн байгууллага	Хууль зүй, дотоод, хөдөлгөөн байгууллага	Улаанбаатар Улаанбаатар	Улаанбаатар Төрийн үйл ажиллагаа байгууллага	Хамтран хариуцагч	
3.3.1.4.	3.3.1.4. Алслагдсан төлөвлөгөөний эрх үйл ажиллагааг зохицуулах, хуульчилсан байгууллагын төлөөллийн тоог нэмэгдүүлэх	Хөдөлгөөн байгууллагын эрх үйл ажиллагааг зохицуулах, хуульчилсан байгууллагын төлөөллийн тоог нэмэгдүүлэх	Шатруур уугаагүй Төлөвлөгөө	2023	-	10	30	50	70	80	90	100	Алслагдсан Төрийн үйл ажиллагаа байгууллага	Алслагдсан Төрийн үйл ажиллагаа байгууллага	Улаанбаатар Улаанбаатар	Улаанбаатар Төрийн үйл ажиллагаа байгууллага	Хамтран хариуцагч	
3.3.1.5.	3.3.1.5. Төрийн байгууллага, албан тунхагтай үйл ажиллагааг зохицуулах, хуульчилсан байгууллагын төлөөллийн тоог нэмэгдүүлэх	Төрийн байгууллага, албан тунхагтай үйл ажиллагааг зохицуулах, хуульчилсан байгууллагын төлөөллийн тоог нэмэгдүүлэх	Шатруур уугаагүй Төлөвлөгөө	2023	-	22	44	66	88	110	132	154	Алслагдсан Төрийн үйл ажиллагаа байгууллага	Алслагдсан Төрийн үйл ажиллагаа байгууллага	Улаанбаатар Улаанбаатар	Улаанбаатар Төрийн үйл ажиллагаа байгууллага	Хамтран хариуцагч	
3.3.1.6.	3.3.1.6. Мэргэжлийн таларх эрх зүйн зохицуулалтыг сайжруулах	Мэргэжлийн таларх эрх зүйн зохицуулалтыг сайжруулах	Шатруур уугаагүй Төлөвлөгөө	2016	1	-	1	1	1	1	1	1	Судалгаа, байгууллага, Алслагдсан Төрийн үйл ажиллагаа	Судалгаа, байгууллага, Алслагдсан Төрийн үйл ажиллагаа	Улаанбаатар Улаанбаатар	Улаанбаатар Төрийн үйл ажиллагаа байгууллага	Хамтран хариуцагч	





























Бэлгэдлийн хэмжээ (хүрээ, гектар)	Зориго, зориул, үйл ашиглагч	Ард хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Туслах төрөл	Эрэлтийн үзүүлэлт										Саямчлалт		Урсгал хэрэгшч	Хамтран хэрэгшч			
					Он	Туслах	2024	2025	2026	2027	2028	2029	2030	Мэдээлэл х сүтээх	Мэдээлэл х сүтээх	Мэдээлэл х сүтээх			Мэдээлэл х сүтээх	Мэдээлэл х сүтээх	Мэдээлэл х сүтээх
5.6.1	Алслагч тэмдэгт газар	5.6.1.1. Алслагч тэмдэгт газар	5.6.1.1. Алслагч тэмдэгт газар	Хууль	2023	-	100	100	100	100	100	100	100	100	100	0.0	Урсгал бүсэд х уусгар	Урсгал бүсэд х уусгар	Урсгал бүсэд х уусгар	Урсгал бүсэд х уусгар	
5.6.2	Төрийн эрхийн эзэрх	5.6.2.1. Төрийн эрхийн бүтэцтэй байгуулалтын алгийн эзэрх	Төлөөтөрийн эзэрх мэт	Хууль	2023	-	100	100	100	100	100	100	100	100	100	0.0	Урсгал бүсэд х уусгар	Урсгал бүсэд х уусгар	Урсгал бүсэд х уусгар	Урсгал бүсэд х уусгар	
5.6.3	Төрийн эрхийн эзэрх	5.6.3.1. Төрийн эрхийн бүтэцтэй байгуулалтын алгийн эзэрх	Хөдөлгөөн шардлага	Хууль, эрх, догоо, хэргийн уураг	2023	1	-	1	-	-	-	-	-	-	-	40.0	Урсгал бүсэд х уусгар	Урсгал бүсэд х уусгар	Урсгал бүсэд х уусгар	Урсгал бүсэд х уусгар	
5.6.4	Төрийн эрхийн эзэрх	5.6.4.1. Төрийн эрхийн бүтэцтэй байгуулалтын алгийн эзэрх	Хөдөлгөөн шардлага	Хууль, эрх, догоо, хэргийн уураг	2023	-	1	-	-	-	-	-	-	-	-	40.0	Урсгал бүсэд х уусгар	Урсгал бүсэд х уусгар	Урсгал бүсэд х уусгар	Урсгал бүсэд х уусгар	
6	Зөвлөгөө, Алслагч эрх төрийн эрхийн эзэрх	6.1.1. Алслагч тэмдэгт үйл ажиллагай, шалгуур үзүүлэлт	Хөдөлгөөн шардлага	Хууль, эрх, догоо, хэргийн уураг	2023	-	1	-	-	-	-	-	-	-	-	0.0	Урсгал бүсэд х уусгар	Урсгал бүсэд х уусгар	Урсгал бүсэд х уусгар	Урсгал бүсэд х уусгар	
6.1	Зөвлөгөө, Алслагч эрх төрийн эрхийн эзэрх	6.1.1. Алслагч тэмдэгт үйл ажиллагай, шалгуур үзүүлэлт	Хөдөлгөөн шардлага	Хууль, эрх, догоо, хэргийн уураг	2023	0.46	0.6	0.6	0.6	0.6	0.6	0.6	0.6	0.6	0.6	0.6	0.6	0.6	0.6	0.6	0.6
6.1.1	Зөвлөгөө, Алслагч эрх төрийн эрхийн эзэрх	6.1.1.1. Алслагч тэмдэгт үйл ажиллагай, шалгуур үзүүлэлт	Хөдөлгөөн шардлага	Хууль, эрх, догоо, хэргийн уураг	2023	0.46	0.6	0.6	0.6	0.6	0.6	0.6	0.6	0.6	0.6	0.6	0.6	0.6	0.6	0.6	0.6
6.1.1.1	Зөвлөгөө, Алслагч эрх төрийн эрхийн эзэрх	6.1.1.1.1. Алслагч тэмдэгт үйл ажиллагай, шалгуур үзүүлэлт	Хөдөлгөөн шардлага	Хууль, эрх, догоо, хэргийн уураг	2023	6	2	2	2	2	2	2	2	2	2	2	2	2	2	2	2
6.1.1.1.1	Зөвлөгөө, Алслагч эрх төрийн эрхийн эзэрх	6.1.1.1.1.1. Алслагч тэмдэгт үйл ажиллагай, шалгуур үзүүлэлт	Хөдөлгөөн шардлага	Хууль, эрх, догоо, хэргийн уураг	2023	6	2	2	2	2	2	2	2	2	2	2	2	2	2	2	2
6.1.1.1.1.1	Зөвлөгөө, Алслагч эрх төрийн эрхийн эзэрх	6.1.1.1.1.1.1. Алслагч тэмдэгт үйл ажиллагай, шалгуур үзүүлэлт	Хөдөлгөөн шардлага	Хууль, эрх, догоо, хэргийн уураг	2023	6	2	2	2	2	2	2	2	2	2	2	2	2	2	2	2
6.1.1.1.1.1.1	Зөвлөгөө, Алслагч эрх төрийн эрхийн эзэрх	6.1.1.1.1.1.1.1. Алслагч тэмдэгт үйл ажиллагай, шалгуур үзүүлэлт	Хөдөлгөөн шардлага	Хууль, эрх, догоо, хэргийн уураг	2023	6	2	2	2	2	2	2	2	2	2	2	2	2	2	2	2
6.1.1.1.1.1.1.1	Зөвлөгөө, Алслагч эрх төрийн эрхийн эзэрх	6.1.1.1.1.1.1.1.1. Алслагч тэмдэгт үйл ажиллагай, шалгуур үзүүлэлт	Хөдөлгөөн шардлага	Хууль, эрх, догоо, хэргийн уураг	2023	6	2	2	2	2	2	2	2	2	2	2	2	2	2	2	2



Бэлдэх боловсролын стандартын дүрэм	Зорилго, зорилт, үйл ашигтай ам	Арга хэмжээ	Шалгуур гүйцэтгэл хугацаа	Эрэлтийн туршилтын										Мэдээллийн гүйцэтгэл		Хяналтын хугацаа (сая төгрөг)	Саямүүлэг хугацаа (сая төгрөг)	Урьдчилсан түвшин хэрэгшээрч хугацаа	Хяналтын хэрэгшээрч хугацаа
				Он	Түвшин	2024	2025	2026	2027	2028	2029	2030	Мэдээллийн хугацаа сүүлчийн хугацаа	Мэдээллийн хугацаа сүүлчийн хугацаа					
6.1.7	Зургаан шугуу болон буцаагч хүрээлэнгээс хэрэгшээрч, хүнлэг болон уламжлалын өргөтгөлийг хөгжүүлж, өргөтгөлийг 6.1.7.1 Зургаан шугуу болон буцаагч хүрээлэнгээс хэрэгшээрч, хүнлэг болон уламжлалын өргөтгөлийг хөгжүүлж, өргөтгөлийг 6.1.7.2 Зургаан шугуу болон буцаагч хүрээлэнгээс хэрэгшээрч, хүнлэг болон уламжлалын өргөтгөлийг хөгжүүлж, өргөтгөлийг	Тус Тус	2023	1	-	-	-	1	-	-	-	-	-	-	-	Урьдчилсан түвшин хэрэгшээрч хугацаа 40.0 Улаан баатар Улаан	Улаан баатар Улаан	Улаан баатар Улаан	Улаан баатар Улаан
6.1.8	Алсын гэрээний хэрэг 6.1.8.1 Алсын гэрээний хэрэг 6.1.8.2 Алсын гэрээний хэрэг	Сурвалжны ажил 6.1.8.1 Алсын гэрээний хэрэг 6.1.8.2 Алсын гэрээний хэрэг	Тус Тус	2023	-	-	-	1	-	-	-	-	-	-	-	Урьдчилсан түвшин хэрэгшээрч хугацаа 40.0 Улаан баатар Улаан	Улаан баатар Улаан	Улаан баатар Улаан	Улаан баатар Улаан
6.1.9	Хурийн эрх 6.1.9.1 Хурийн эрх 6.1.9.2 Хурийн эрх	Хурийн эрх 6.1.9.1 Хурийн эрх 6.1.9.2 Хурийн эрх	Тус Тус	2023	-	-	-	1	-	-	-	-	-	-	-	Урьдчилсан түвшин хэрэгшээрч хугацаа 40.0 Улаан баатар Улаан	Улаан баатар Улаан	Улаан баатар Улаан	Улаан баатар Улаан
6.1.10	Алсын гэрээний хэрэг 6.1.10.1 Алсын гэрээний хэрэг 6.1.10.2 Алсын гэрээний хэрэг	Алсын гэрээний хэрэг 6.1.10.1 Алсын гэрээний хэрэг 6.1.10.2 Алсын гэрээний хэрэг	Тус Тус	2023	1	1	-	-	-	-	-	-	-	-	-	Урьдчилсан түвшин хэрэгшээрч хугацаа 40.0 Улаан баатар Улаан	Улаан баатар Улаан	Улаан баатар Улаан	Улаан баатар Улаан
6.1.11	Хурийн эрх 6.1.11.1 Хурийн эрх 6.1.11.2 Хурийн эрх	Хурийн эрх 6.1.11.1 Хурийн эрх 6.1.11.2 Хурийн эрх	Тус Тус	2023	1	-	-	1	-	-	-	-	-	-	-	Урьдчилсан түвшин хэрэгшээрч хугацаа 40.0 Улаан баатар Улаан	Улаан баатар Улаан	Улаан баатар Улаан	Улаан баатар Улаан
6.1.12	Алсын гэрээний хэрэг 6.1.12.1 Алсын гэрээний хэрэг 6.1.12.2 Алсын гэрээний хэрэг	Алсын гэрээний хэрэг 6.1.12.1 Алсын гэрээний хэрэг 6.1.12.2 Алсын гэрээний хэрэг	Тус Тус	2023	1	1	-	-	-	-	-	-	-	-	-	Урьдчилсан түвшин хэрэгшээрч хугацаа 40.0 Улаан баатар Улаан	Улаан баатар Улаан	Улаан баатар Улаан	Улаан баатар Улаан
6.1.13	Хурийн эрх 6.1.13.1 Хурийн эрх 6.1.13.2 Хурийн эрх	Хурийн эрх 6.1.13.1 Хурийн эрх 6.1.13.2 Хурийн эрх	Тус Тус	2023	1	-	-	1	-	-	-	-	-	-	-	Урьдчилсан түвшин хэрэгшээрч хугацаа 40.0 Улаан баатар Улаан	Улаан баатар Улаан	Улаан баатар Улаан	Улаан баатар Улаан

















































Боловсролын үнэмлэхүй дарааллын үндсэн дээр	Зорилго, зорилт, үйл ажиллагаа	Арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Эхний жил	Зорилт үүсгэн										Урьдчилсан үнэмлэхүй үзүүлэлт	Мэдээллийн гуримтлал	Самууныг	Урьдчилсан үнэмлэхүй үзүүлэлт	Хяналтын зардал				
					Сурь-түүхэн		Хэрэгжүүлэх жил																
					Он	Түүхэн	2024	2025	2026	2027	2028	2029	2030	Мэдээлэх чиглэл						Мэдээлэх чиглэл үзүүлэлт	Мэдээлэх чиглэл үзүүлэлт	Мэдээлэх чиглэл үзүүлэлт	Мэдээлэх чиглэл үзүүлэлт
10.3.1	10.3.1.1	10.3.1.1	Боловсролын үнэмлэхүй дарааллын үндсэн дээр	Тус	2023	-	-	1	-	-	-	-	-	-	-	-	-	Урьдчилсан үзүүлэлт: 100% төлөв бусад үзүүлэлт	Засгийн гарын Хэрэг зохиох газар	Засгийн гарын Хэрэг зохиох газар, Судалгааны байгууллага	Хяналтын зардал		
10.3.2	10.3.2.1	10.3.2.1	Боловсролын үнэмлэхүй дарааллын үндсэн дээр	Тус	2023	-	-	1	-	-	-	-	-	-	-	-	-	Урьдчилсан үзүүлэлт: 170.0 бусад үзүүлэлт	Засгийн гарын Хэрэг зохиох газар	Засгийн гарын Хэрэг зохиох газар	Хяналтын зардал		
10.3.3	10.3.3.1	10.3.3.1	Шинжлэх ухаан, технологийн салбарын үнэмлэхүй дарааллын үндсэн дээр	Тус	2023	-	-	1	-	-	-	-	-	-	-	-	-	Урьдчилсан үзүүлэлт: 360.0 бусад үзүүлэлт	Ажилтгий гэмдэх газар	Ажилтгий гэмдэх газар	Хяналтын зардал		
<b>Нийт дүн</b>																							

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2024 оны 07 дугаар  
сарын 09-ний өдөр

Дугаар 06

Улаанбаатар  
хот

### **Зарим Байнгын хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай**

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.3.5 дахь заалт, 25 дугаар зүйлийн 25.1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1.4 дэх заалтыг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Монгол Улсын Их Хурлын гишүүн Дамдинсүрэнгийн Жаргалсайхан, Болдын Уянга нарыг Улсын Их Хурлын Аж үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны, Бадрахын Найдалаа, Өлзийхүүгийн Шижир, Лутаагийн Энхнасан нарыг Улсын Их Хурлын Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны, Пүрэвсүрэнгийн Наранбаярыг Улсын Их Хурлын Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хорооны, Наранцэцэгийн Алтаншагай, Сүхбаатарын Эрдэнэболд нарыг Улсын Их Хурлын Инновац, цахим бодлогын байнгын хорооны, Баатаржавын Мөнхсоёл, Цэвэгдоржийн Туваан нарыг Улсын Их Хурлын Нийгмийн бодлогын байнгын хорооны, Жамбын Батсуурийг Улсын Их Хурлын Төрийн байгуулалтын байнгын хорооны, Очирбатын Амгаланбаатар, Тогмидын Доржханд, Бадамдоржийн Пунсалмаа нарыг Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны, Оюунсайханы Алтангэрэлийг Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хорооны, Цэндийн Баатархүүг Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хорооны бүрэлдэхүүнээс тус тус чөлөөлсүгэй.

2. Монгол Улсын Их Хурлын гишүүн Наранцэцэгийн Алтаншагай, Нанзадын Наранбаатар, Өлзийхүүгийн Шижир, Баттөмөрийн Энхбаяр нарыг Улсын Их Хурлын Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны, Болдын Уянгыг Улсын Их Хурлын Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны, Очирбатын Амгаланбаатар, Бадрахын Найдалаа, Сүхбаатарын Эрдэнэбат нарыг Улсын Их Хурлын Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хорооны, Бадамдоржийн Пунсалмааг Улсын Их Хурлын Инновац, цахим бодлогын байнгын хорооны, Мөнгөнцогийн Ганхүлэг, Лутаагийн Энхнасан нарыг Улсын Их Хурлын Нийгмийн бодлогын байнгын хорооны, Өлзийхүүгийн Шижирийг Улсын Их Хурлын Төрийн байгуулалтын байнгын хорооны, Баатаржавын Мөнхсоёл, Банзрагчийн Түвшин, Даваагийн Цогтбаатар нарыг Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны, Хүрэлбаатарын Баасанжаргал, Сүхбаатарын Эрдэнэболд нарыг Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хорооны, Жамбын Батсуурийг Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хорооны гишүүнээр тус тус баталсугай.

3. Энэ тогтоолыг 2024 оны 07 дугаар сарын 09-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**Д.АМАРБАЯСГАЛАН**

᠑᠙᠘᠗ он / ᠑᠗ - ᠑᠙᠙᠗ он / ᠑᠗ - ᠑᠙᠙᠗ он / ᠑᠗

᠑᠙᠙᠗ он

᠑᠙᠙᠗ он / ᠑᠗ - ᠑᠙᠙᠗ он / ᠑᠗

### Индриг Фолг да Улс Норг да Довлигд

᠑᠙᠙᠗ он / ᠑᠗ - ᠑᠙᠙᠗ он / ᠑᠗

᠑᠙᠙᠗ он / ᠑᠗ - ᠑᠙᠙᠗ он / ᠑᠗

᠑᠙᠙᠗ он / ᠑᠗ - ᠑᠙᠙᠗ он / ᠑᠗

᠑᠙᠙᠗ он / ᠑᠗ - ᠑᠙᠙᠗ он / ᠑᠗

᠑᠙᠙᠗ он / ᠑᠗ - ᠑᠙᠙᠗ он / ᠑᠗

᠑᠙᠙᠗ он / ᠑᠗ - ᠑᠙᠙᠗ он / ᠑᠗

᠑᠙᠙᠗ он / ᠑᠗ - ᠑᠙᠙᠗ он / ᠑᠗



## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2024 оны 07 дугаар  
сарын 09-ний өдөр

Дугаар 07

Улаанбаатар  
хот

Улсын Их Хурлын Ерөнхий нарийн  
бичгийн даргын үүрэгт ажлаас  
чөлөөлөх тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2 дахь хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 111 дүгээр зүйлийн 111.2 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Дамдины Энхбатыг Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн даргын үүрэгт ажлаас чөлөөлсүгэй.

2.Энэ тогтоолыг 2024 оны 07 дугаар сарын 09-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА

Д.АМАРБАЯСГАЛАН



**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ**

2024 оны 07 дугаар  
сарын 09-ний өдөр

Дугаар 08

Улаанбаатар  
хот

**Улсын Их Хурлын Ерөнхий нарийн  
бичгийн даргыг томилох тухай**

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2 дахь хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 111 дүгээр зүйлийн 111.2 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Барсүрэнгийн Баасандоржийг Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн даргаар томилсугай.

2. Энэ тогтоолыг 2024 оны 07 дугаар сарын 09-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**Д.АМАРБАЯСГАЛАН**







## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2024 оны 07 дугаар  
сарын 09-ний өдөр

Дугаар 09

Улаанбаатар  
хот

### Зарим Байнгын хорооны дарга нарыг сонгох тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.6, 25.7 дахь хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1, 23.2 дахь хэсэг, санал хураалтын дүнг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Улсын Их Хурлын зарим Байнгын хорооны даргаар дараах Улсын Их Хурлын гишүүдийг сонгосугай:

1/Аж үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны даргаар Сайнхүүгийн Ганбаатар;

2/Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны даргаар Буланы Бейсен;

3/Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хорооны даргаар Чинбатын Ундрам;

4/Ёс зүй, дэгийн байнгын хорооны даргаар Баярмагнайн Баярбаатар;

5/Инновац, цахим бодлогын байнгын хорооны даргаар Жаргалсайханы Золжаргал;

6/Нийгмийн бодлогын байнгын хорооны даргаар Лутаагийн Энхнасан;

7/Эдийн засгийн байнгын хорооны даргаар Ренчинбямбын Сэддорж.

2. Энэ тогтоолыг 2024 оны 07 дугаар сарын 09-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**Д.АМАРБАЯСГАЛАН**





## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2024 оны 07 дугаар  
сарын 09-ний өдөр

Дугаар 10

Улаанбаатар  
хот

### Тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин есдүгээр зүйлийн 4 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.3 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. “Журам батлах тухай” Монгол Улсын Их Хурлын 2020 оны 05 дугаар сарын 13-ны өдрийн 50 дугаар тогтоолын үндэслэх хэсгийн болон тус тогтоолын хавсралтаар баталсан “Монгол Улсын Засгийн газрын гишүүний тангараг өргөх журам”-ын 1 дэх заалтын “31 дүгээр” гэснийг “27 дугаар” гэж, мөн журмын 10 дахь заалтын “Засгийн газрын гишүүн тангаргийг хамтаар буюу ганцаар өргөж болох бөгөөд хамтаар өргөхөд Засгийн газрын бүрэлдэхүүний тухай хуульд заасан дарааллын дагуу тангаргийг ээлжээр уншина.” гэснийг “Засгийн газрын гишүүд тангаргийг хамтаар өргөх бөгөөд насаар хамгийн ахмад гишүүн тангаргийг уншиж, бусад гишүүн давтан хэлнэ. Засгийн газрын гишүүн нөхөн томилогдсон тохиолдолд тангаргийг ганцаар өргөж болно.” гэж өөрчилсүгэй.

2. Энэ тогтоолыг 2024 оны 07 дугаар сарын 09-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**Д.АМАРБАЯСГАЛАН**





## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2024 оны 07 дугаар  
сарын 10-ны өдөр

Дугаар 11

Улаанбаатар  
хот

### Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.3.10 дахь заалт, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2, 45 дугаар зүйлийн 45.3 дахь хэсэг, санал хураалтын дүнг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Монгол Улсын Их Хурлаас 2024 оны 05 дугаар сарын 16-ны өдөр баталсан Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийг 2024 оны Улсын Их Хурлын ээлжит сонгуулийн дүнд байгуулагдсан Улсын Их Хурлын хуралдааны дэг гэж хүлээн зөвшөөрсөнд тооцугай.

2. Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд өөрчлөлт оруулах шаардлагатай гэж үзвэл Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.1.1 дэх заалтад заасны дагуу шийдвэрлэж байхаар тогтоосугай.

3. Энэ тогтоолыг 2024 оны 07 дугаар сарын 10-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**Д.АМАРБАЯСГАЛАН**





## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2024 оны 07 дугаар  
сарын 10-ны өдөр

Дугаар 12

Улаанбаатар  
хот

### Хуулийн төсөл буцаах тухай

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.12 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Монгол Улсын Засгийн газраас 2024 оны 07 дугаар сарын 08-ны өдөр Улсын Их Хуралд Засгийн газрын бүтцийн тухай, Засгийн газрын бүрэлдэхүүний тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Нийгмийн халамжийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Соёлын бүтээлч үйлдвэрлэлийг дэмжих тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Дипломат албаны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын ерөнхий хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Боловсролын ерөнхий хуульд өөрчлөлт оруулах тухай, Донорын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үндэсний баялгийн сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулиудын төслийг буцаах нь зүйтэй гэсэн Байнгын хорооны санал, дүгнэлтийг нэгдсэн хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн тул хууль санаачлагчид буцаасугай.

МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА

Д.АМАРБАЯСГАЛАН







## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2024 оны 07 дугаар  
сарын 10-ны өдөр

Дугаар 13

Улаанбаатар  
хот

### Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвчийг шинэчлэн батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасныг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.“Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвч”-ийг хавсралтаар шинэчлэн баталсугай.

2.Энэ тогтоолыг баталсантай холбогдуулан “Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвчийг шинэчлэн батлах тухай” Монгол Улсын Их Хурлын 2020 оны 07 дугаар сарын 07-ны өдрийн 07 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

3.Энэ тогтоолыг 2024 оны 07 дугаар сарын 10-ны өдөр баталсан Засгийн газрын бүтцийн тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА

Д.АМАРБАЯСГАЛАН



Монгол Улсын Их Хурлын 2024 оны  
13 дугаар тогтоолын хавсралт

**ТӨРИЙН ЗАХИРГААНЫ БАЙГУУЛЛАГЫН ТОГТОЛЦОО,  
БҮТЦИЙН ЕРӨНХИЙ БҮДҮҮВЧ**

<b>Эрхлэх асуудлын хүрээ, харьяалал</b>	<b>Засгийн газрын тохируулагч агентлаг</b>	<b>Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг</b>
Монгол Улсын Ерөнхий сайдын эрхлэх асуудлын хүрээнд	-Тагнуулын ерөнхий газар -Төрийн тусгай хамгаалалтын газар	-Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар -Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газар
Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд		-Оюуны өмчийн газар
Монгол Улсын Шадар сайдын эрхлэх асуудлын хүрээнд		-Хөрөнгө оруулалт, худалдааны газар -Төрийн худалдан авах ажиллагааны газар -Монополын эсрэг газар
Монгол Улсын Шадар сайдын эрхлэх асуудлын хүрээнд	-Онцгой байдлын ерөнхий газар -Стандарт, хэмжил зүйн газар	
Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын эрхлэх асуудлын хүрээнд		
Монгол Улсын сайд, Хяналт, үнэлгээний Үндэсний хорооны даргын эрхлэх асуудлын хүрээнд		-Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх газар
Монгол Улсын сайд, 20 минутын хот Үндэсний хорооны даргын эрхлэх асуудлын хүрээнд		



Монгол Улсын сайд, Боомтын сэргэлтийн Үндэсний хорооны даргын эрхлэх асуудлын хүрээнд		
Гадаад харилцааны сайдын эрхлэх асуудлын хүрээнд		
Сангийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд		-Гаалийн ерөнхий газар -Татварын ерөнхий газар
Хууль зүй, дотоод хэргийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд	-Цагдаагийн ерөнхий газар -Хил хамгаалах ерөнхий газар	-Улсын бүртгэлийн ерөнхий газар -Архивын ерөнхий газар -Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар -Гадаадын иргэн, харьяатын газар -Шүүх шинжилгээний ерөнхий газар
Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд		-Ашигт малтмал, газрын тосны газар -Үндэсний геологийн алба
Батлан хамгаалахын сайдын эрхлэх асуудлын хүрээнд	-Зэвсэгт хүчний жанжин штаб	
Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд		-Цаг уур, орчны шинжилгээний газар -Усны газар -Ойн газар
Боловсролын сайдын эрхлэх асуудлын хүрээнд		-Боловсролын ерөнхий газар
Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын эрхлэх асуудлын хүрээнд		-Нийгмийн даатгалын ерөнхий газар -Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар -Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар -Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын ерөнхий газар
Зам, тээврийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд	-Иргэний нисэхийн ерөнхий газар	



Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайдын эрхлэх асуудлын хүрээнд		-Соёл, урлагийн газар -Биеийн тамир, спортын улсын хороо
Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайдын эрхлэх асуудлын хүрээнд		
Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд		-Мал эмнэлгийн ерөнхий газар -Жижиг, дунд үйлдвэрийн газар
Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын эрхлэх асуудлын хүрээнд		-Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газар
Эрчим хүчний сайдын эрхлэх асуудлын хүрээнд		
Эрүүл мэндийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд		-Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар -Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газар

---оОо---













## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2024 оны 07 дугаар  
сарын 10-ны өдөр

Дугаар 14

Улаанбаатар  
хот

### **Зарим Байнгын хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай**

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.3.5 дахь заалт, 25 дугаар зүйлийн 25.1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1.4 дэх заалтыг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Монгол Улсын Их Хурлын гишүүн Салдангийн Одонтуяа, Баттогтохын Чойжилсүрэн нарыг Улсын Их Хурлын Аж үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны, Сандагийн Бямбацогтыг Улсын Их Хурлын Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны, Ганзоригийн Тэмүүлэнг Улсын Их Хурлын Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны, Жанчивын Галбадрахыг Улсын Их Хурлын Ёс зүй, дэгийн байнгын хорооны, Лувсаннъямын Гантөмөр, Пүрэвжавын Сайнзориг нарыг Улсын Их Хурлын Инновац, цахим бодлогын байнгын хорооны, Тогтмолын Мөнхсайхан, Эрдэнэбилэгийн Одбаяр, Лувсанцэрэнгийн Энх-Амгалан нарыг Улсын Их Хурлын Нийгмийн бодлогын байнгын хорооны, Болдын Жавхланг Улсын Их Хурлын Төрийн байгуулалтын байнгын хорооны, Сайнбуянгийн Амарсайхан, Чинбатын Ундрам нарыг Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны, Борхүүгийн Дэлгэрсайхан, Буяагийн Тулга, Жадамбаагийн Энхбаяр нарыг Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хорооны, Жамбын Батсуурь, Жадамбын Бат-Эрдэнэ нарыг Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хорооны бүрэлдэхүүнээс тус тус чөлөөлсүгэй.

2. Монгол Улсын Их Хурлын гишүүн Пүрэвжавын Сайнзориг, Ганзоригийн Тэмүүлэн нарыг Улсын Их Хурлын Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны, Жанчивын Галбадрах, Чинбатын Ундрам нарыг Улсын Их Хурлын Инновац, цахим бодлогын байнгын хорооны, Жадамбын Бат-Эрдэнийг Улсын Их Хурлын Төрийн байгуулалтын байнгын хорооны, Баттөмөрийн Энхбаярыг Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хорооны, Болдын Жавхлан, Саруулсайханы Цэнгүүн нарыг Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хорооны гишүүнээр тус тус баталсугай.

3. Энэ тогтоолыг 2024 оны 07 дугаар сарын 10-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**Д.АМАРБАЯСГАЛАН**





## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2024 оны 07 дугаар  
сарын 10-ны өдөр

Дугаар 15

Улаанбаатар  
хот

### Зарим Байнгын хорооны дарга нарыг сонгох тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.6, 25.7 дахь хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1, 23.2 дахь хэсэг, санал хураалтын дүнг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Улсын Их Хурлын зарим Байнгын хорооны даргаар дараах Улсын Их Хурлын гишүүдийг сонгосугай:

1/Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны даргаар Ганзоригийн Тэмүүлэн;

2/Төрийн байгуулалтын байнгын хорооны даргаар Жадамбын Бат-Эрдэнэ;

3/Төсвийн байнгын хорооны даргаар Цэрэнпилийн Даваасүрэн;

4/Хууль зүйн байнгын хорооны даргаар Дамдины Цогтбаатар.

2.Энэ тогтоолыг 2024 оны 07 дугаар сарын 10-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**Д.АМАРБАЯСГАЛАН**





## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2024 оны 07 дугаар  
сарын 10-ны өдөр

Дугаар 16

Улаанбаатар  
хот

### Монгол Улсын Их Хурлын зарим дэд хорооны бүрэлдэхүүний тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.3.5 дахь заалт, 27 дугаар зүйлийн 27.3 дахь хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.3 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Монгол Улсын Их Хурлын зарим дэд хороодыг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай:

#### 1/Улсын Их Хурлын гишүүний халдашгүй байдлын:

- Норовын Алтанхуяг
- Халтмаагийн Баттулга
- Жадамбын Бат-Эрдэнэ
- Сандагийн Бямбацогт
- Лувсаннъямын Гантөмөр
- Цэрэнпилийн Даваасүрэн
- Баттогтохын Чойжилсүрэн
- Лувсанцэрэнгийн Энх-Амгалан
- Жадамбын Энхбаяр

#### 2/Төсвийн зарлагын хяналтын:

- Далайн Батбаяр
- Ринчиндоржийн Батболд
- Жигжидийн Батжаргал
- Дамбын Батлут
- Хүрэлбаатарын Булгантуяа
- Пүрэвжавын Ганзориг
- Батжаргалын Заяабал
- Гонгорын Дамдинням
- Загджавын Мэндсайхан
- Даваахүүгийн Пүрэвдаваа
- Банзрагчийн Түвшин
- Даваагийн Цогтбаатар

#### 3/Хүний эрхийн:



- 1.Хүрэлбаатарын Баасанжаргал
- 2.Бат-Өлзийн Бат-Эрдэнэ
- 3.Мөнхтөрийн Нарантуяа-Нара
- 4.Одсүрэнгийн Номинчимэг
- 5.Пүрэвжавын Сайнзориг
- 6.Цэндийн Сандаг-Очир
- 7.Хишигдэмбэрэлийн Тэмүүжин
- 8.Гончигдоржийн Уянгахишиг
- 9.Даваагийн Цогтбаатар
- 10.Сүхбаатарын Эрдэнэболд

**4/Тогтвортой хөгжлийн зорилгын:**

- 1.Мягмарсүрэнгийн Бадамсүрэн
- 2.Отгоншарын Батнайрамдал
- 3.Пүрэвийн Батчимэг
- 4.Энхбаярын Батшугар
- 5.Батбаярын Жаргалан
- 6.Мэндбаярын Мандхай
- 7.Баатаржавын Мөнхсоёл
- 8.Лхагвасүрэнгийн Соронзонболд
- 9.Агваанлуvsангийн Ундраа
- 10.Мөнхчулууны Энхцэцэг

2.Энэ тогтоолыг 2024 оны 07 дугаар сарын 10-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**Д.АМАРБАЯСГАЛАН**



06. Өвөрмөц дэд хэргийн  
07. Өвөрмөц дэд хэргийн  
08. Өвөрмөц дэд хэргийн

3/Өвөрмөц дэд хэргийн:

- 0. Өвөрмөц дэд хэргийн өвөрмөц
- 1. Өвөрмөц дэд хэргийн өвөрмөц
- 2. Өвөрмөц дэд хэргийн өвөрмөц
- 3. Өвөрмөц дэд хэргийн өвөрмөц
- 4. Өвөрмөц дэд хэргийн өвөрмөц
- 5. Өвөрмөц дэд хэргийн өвөрмөц
- 6. Өвөрмөц дэд хэргийн өвөрмөц
- 7. Өвөрмөц дэд хэргийн өвөрмөц
- 8. Өвөрмөц дэд хэргийн өвөрмөц
- 9. Өвөрмөц дэд хэргийн өвөрмөц
- 10. Өвөрмөц дэд хэргийн өвөрмөц

1/Өвөрмөц дэд хэргийн өвөрмөц:

- 0. Өвөрмөц дэд хэргийн өвөрмөц
- 1. Өвөрмөц дэд хэргийн өвөрмөц
- 2. Өвөрмөц дэд хэргийн өвөрмөц
- 3. Өвөрмөц дэд хэргийн өвөрмөц
- 4. Өвөрмөц дэд хэргийн өвөрмөц
- 5. Өвөрмөц дэд хэргийн өвөрмөц
- 6. Өвөрмөц дэд хэргийн өвөрмөц
- 7. Өвөрмөц дэд хэргийн өвөрмөц
- 8. Өвөрмөц дэд хэргийн өвөрмөц
- 9. Өвөрмөц дэд хэргийн өвөрмөц
- 10. Өвөрмөц дэд хэргийн өвөрмөц

3. Өвөрмөц дэд хэргийн өвөрмөц 06-08 өвөрмөц дэд хэргийн өвөрмөц ..

Өвөрмөц дэд хэргийн өвөрмөц

Өвөрмөц дэд хэргийн өвөрмөц





**Хаяг:**

“Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн редакц  
Улаанбаатар-14201, Төрийн ордон 124 тоот  
И-мэйл: [turiin\\_medeel@parliament.mn](mailto:turiin_medeel@parliament.mn)

**Утас:** 262420

Хэвлэлийн хуудас: 10.5

**Индекс: 200003**